



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.10.12, БААСАН ~ №201 (1000)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Монголын баялагт итгэж байгаа бол банкуудад нь ч итгэх ёстой

Төсвийг батлахдаа хөгжлийн бодлоготой уялдуулах нь зөв юм. > 2



ШИЛДЭГ
НИЙТЛЭЛҮҮД ТАНД
ХҮРЧ БАЙНА > 9

1072 хувьцаатай иргэдийн 72 хувь нь үнэт цаасны дансгүй

Иргэдийн мэдлэгийг сайжруулахгүйгээр хөрөнгийн зах зээл хөгжихгүй. > 12

ZGM DAILY

FULL
ENGLISH PAGE
INSIDE

> 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Нөхөн сонгуулийн товыг түдгэлзүүлсэн Цэцийн дүгнэлтийг УИХ хүлээж авахгүй гэж шийдэв. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг өөрчлөхийг УИХ дэмжив. Ерөнхий сайд У.Хүрэлсүхийг АНЭУ-д айлчлахыг тус улсын Ерөнхий сайд урьжээ. БНФУ-аас Монголд суух Элчин сайд Филипп Мэрлин Итгэмжлэх жуух бичгээ өргөн бариллаа.

ЭДИЙН ЗАСАГ

Мөнгөний бодлогын ирэх оны төсөлд санал авах нээлттэй хэлэлцүүлэг боллоо. Монгол Улс энэ оны эхний есөн сард 27 сая тонн нүүрс экспортолжээ. БНХАУ санхүүгийн тогтолцоонд чухал ач холбогдолтой компаниудынхаа тоог нэмнэ. ТОП 20 индекс 20434.38 нэгж болж, 0.2 хувиар буурав.



НИЙГЭМ

Нийслэлийн 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж эхэлжээ. Сурагчдыг үдийн хоолтой болгоход 1,100 тогооч, 800 хоол зүйч шаардлагатай гэв. Хотын захиргааны байрыг зарсан мөнгөөр Яармагт барих шинэ байрыг санхүүжүүлнэ гэв. Айлуудын янданд суурилуулах шүүлтүүр нэг бүр нь 200 ам.долларын үнэтэй.

ДЭЛХИЙ

Нөөцийн тайлан нийтлэгдсэний дараа Brent тосны үнэ 81.6 ам.доллар болж буурлаа. Японы паспорттой иргэд визгүй нэвтрэх улсын тоогоор 2018 онд дэлхийд тэргүүлээ. Нэг удаагийн савыг 2021 оноос бүрмөсөн хориглохыг ЕХ-ны парламент дэмжив. ОХУ-д сүүлийн арван жилд эрдэмтэд долоон хувиар цөөрснийг статистик харуулав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

2018.10.12



14° | 0°


ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭМЖҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

ТӨМӨР ЗАМГҮЙГЭЭР 42 САЯ ТОННЫГ ЭКСПОРТЛОХ БОЛОМЖТОЙ ЮУ



Нүүрсний экспортыг 42 сая тоннд хүргэхээр төсвийн төсөлд тусгачихсан. Боломжоо тултал нь ашиглаад ч жилд 30 гаруй сая тонныг экспортолж байгаа энэ үед уг зорилт эдийн засагчдын дунд маргаан дагуулж эхэллээ. ►3

С.Батсайхан / ЗГМ ©



ЗГМ: СЭДЭВ

Төр “За” гэхийн оронд “За, яах вэ” гэж хандаж байна

П.Батбөх
ЗГМ

“Монгол Улсын хэмжээнд цэцэрлэгт хамрагдах насны 146 мянган хүүхэд байгаа. Тэдний 114 мянгыг цэцэрлэгт хамруулах боломжтой, үлдсэн 30 орчим мянган хүүхдийг ирэх жил бүрэн хамруулна” гэж салбарын сайд Ц.Цогзолмаа хэлсэн.

Харин Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийн холбооныхон 73 мянган хүүхэд өнөө жил цэцэрлэгт хамрагдаж чадалгүй үлдсэн гэв. Гэртээ цоожлуулж үлдсэн эдгээр хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмших эрхээ эдэлж чадахгүйн дээр, ямар нэгэн золгүй тохиолдлын золиос болох эрсдэлд ойрхон байна.

2016, 2017 оны байдлаар 17 мянга орчим хүүхэд “Хүүхэд харах үйлчилгээний төв”-д хамрагдаж, сургуулийн өмнөх насны боловсрол эзэмшсэн байна. Улмаар энэ онд 5.8 тэрбум төгрөгийг эдгээр төвийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж байна.

► 5

ЗГМ: ЗОЧИН

Хэрэв Н.Төгсцогт Монголдоо үлдсэн бол нөгөө хэд шигээ зэврээд дуусна

Б.Энхжин
ЗГМ

Монгол Улсын гавьяат тамирчин, мэргэжлийн боксын дэлхийн аварга асан Ч.Цэвээнпүрэвтэй уулзаж ярилцлаа. Монголын боксын сургалт, дасгалжуулалт хоцрогдож, тамирчид нь өсөн дэвжиж чадахгүй байгааг тэрбээр шүүмжилсэн юм. Мөн Н.Төгсцогт мэргэжлийн бокст орсон нь хамгийн зөв шийдвэр хэмээн үздэгээ илэрхийлэв.

-Та сүүлийн үед нам жим байлаа. Ямар ажил амжуулаад явна вэ?

-Олон нийт, байгаль орчинд чиглэсэн ажил хийгээд явна. Бяцхан тархийг зохиосон доктор Л.Дуурсахын багтай хамт Монголыг ногоон, утаагүй болгох төслүүд дээр ажиллаж байна. Би үүнийг нь олон нийтэд сурталчлан таниулах үүрэгтэй.

Боксоосоо бол хөндийрөөгүй. Тулааны клубүүдэд зөвлөх хийж байгаа. Миний ганц чаддаг, сурсан зүйл энэ шүү дээ.

► 6

АЛТ

1206.70
1.11%

ЗЭС

6239
0.84%

10-ЧИНГИС БОНД

95.946
0.79%

ХУРАЛДАЙ БОНД

110.04
0.00%

ГЭРЭГЭ БОНД

97.170
0.01%

АМ.ДОЛЛАР

2563.77

ЮАНЬ

370.06

РУБЛЬ

38.39

Улс төр

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Монголын баялагт итгэж байгаа бол банкуудад нь ч итгэх ёстой

*Төсвийг батлах-
даа хөгжлийн
бодлоготой уял-
дуулах нь зөв юм*

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

Улсын төсвийн хэлэлцүүлгийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хийж буй энэ үед тойргуудын хөрөнгө оруулалтын асуудал гишүүдийн марааны сэдэв болж байна. Засгийн газар төсвийн төслийг боловсруулахдаа гишүүдээс сонгогдсон тойрогт нь хийгдэх асуудлуудаас алийг нь шийдүүлэх талаар санал хүртэл авсан аж. Гишүүдийн хэлж буйгаар тойргийн хөрөнгө оруулалтын санал авахдаа таван тэрбум төгрөгт бастаах хязгаарыг тогтоосон аж.

Энэ талаар болон парламентаар хэлэлцэж буй зарим хуулийн төслийн талаар УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагватай ярилцлаа.

-Төсвийн хэлэлцүүлгийн үеэр гишүүдийн сонгогдсон тойрогт хийх хөрөнгө оруулалтын саналыг авсан байна. Энэ үнэн үү?

-Гишүүд өөрийн сонгогдсон тойргоос илүү улс орны язгуур эрх ашгийг бодож баймаар байна. Миний хувьд төсвийн хэлэлцүүлгийн үед хэд хэдэн асуудалд анхаарлаа хандуулаасай гэж хүсэж байна. Нэгдүгээрт, ЖДҮ-ийг дэмжих талаар бүх гишүүн ярьдаг. Гэтэл тэнд ажиллах мэргэжилтэй ажилтан байгаа юм уу, байхгүй. Сүүлийн 2-3 жилд мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр “Ажилсаг Монгол хөтөлбөр”-ийн талаар их ярьсан. Өнгөрсөн жил нэг тэрбум төгрөг энэ чиглэлд тавиад гурван мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх сургуулийн асуудлыг шийдсэн. Үүнийг олон удаа ярьсны хүчинд 2019 оны төсөвт МСҮТ-д суралцаж байгаа хүүхэд бүрт 100 мянган төгрөгийн тэтгэлэг өгөхөөр болсонд талархаж байгаа. Энэ бол хөдөлмөрийн зах зээлд чухлаар тавигдах бодлогын том асуудал юм. Түүнээс гадна газар тариалангийн салбарт анхаарлаа хандуулах ёстой. Атрын III аяныг арван жилийн өмнө хэрэгжүүлж байсан. Харин одоо дөрөв дэх аяныг эхлүүлэх цаг болсон. Цаг уурын нөхцөл байдлаас үл хамаарах байдлаар энэ салбарыг авч явах гэх мэт бодлогын томоохон асуудлыг төсвийн хэлэлцүүлгийн үеэр хөндөж, анхаарлаа хандуулан арга хэмжээ авах нь зөв. Эцсийн эцэст, нийт ард түмэн яаж ажил орлоготой болох, ингэснээр төсөв хэрхэн нэмэгдэх гэдэг талаас нь яримаар байна. Тэгэхгүйгээр гишүүн бүр өөрийн сонгогдсон тойргийн жижиг асуудлуудаа төсвийн хэлэлцүүлгээр ярьж, хуваарилсаар байгаад хөрөнгө



Гишүүн бүр өөрийн сонгогдсон тойргийн жижиг асуудлуудыг төсвийн хэлэлцүүлгээр ярьж, хуваарилсаар байгаад хөрөнгө оруулалт байнд ч үгүй, банзанд ч үгүй болж байна.

Б.Хасуй / ЗГМӨ

оруулалт байнд ч үгүй, банзанд ч үгүй болж байгаа юм л даа.

-Гэтэл гишүүд тойргийнхоо хөрөнгө оруулалтын саналыг дунджаар тав таван тэрбум төгрөгт багтааж өгсөн байна. Танай тойрогт жишээлбэл хэд орчим төгрөгийн хөрөнгө оруулалт суулгасан байна вэ?

-Ажлын хэсгийн нөхдийн хэлж буйгаар зарим тойргийн хөрөнгө оруулалт 30, 40 тэрбум төгрөг хүрсэн гэсэн. Гэхдээ хэний тойрогт хэдэн төгрөг хуваарилж байгааг би судлахыг хүсээгүй. Энэ бол Ажлын хэсгийнхний хийх ажил. Улсын төсөв дээр манай тойрогт хөрөнгө оруулалт хийх тав орчим тэрбум төгрөг тавьсан.

Аргаа бараад томоохон гүйлгээг Монголбанкнаар дамжуулъя гэж байна

Гэтэл зам, эрчим хүчний гэх мэт томоохон асуудлаа шийдмээр байдаг. Дээрээс нь бусад тулгамдсан асуудал маш олонтой. Тухайлбал, СХД бараг тэр чигээрээ гэр хороолол, Улаанбаатарын утааны гол бүс

Төсөв дээр ямар тойрог хамгийн их асуудалтай байгааг хармаар байна. УИХ-ын гишүүн гэдэг ард түмний эрх ашгийг дээдлэх ёстойгоос бус зөвхөн тойргоо анхаарах ёстой биш. Яагаад СХД-т анхаарах ёстой вэ гэхээр тэнд зам харилцаа, цахилгаан эрчим хүч, цэцэрлэг сургуулийн хүртээмж муу, утааны асуудал маш их. Цэцэрлэг, сургууль дээр мөнгө суулгахаар тендер дээр нь заргалдсаар байтал төсөв нь буцаад татагдчих шахдаг.

-Энэ жилийн төсвийг боловсруулахдаа сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалтыг илүү анхаарч, гурван ээлжээр хичээллэдэг, сугалаагаар сургуулийн өмнөх насны боловсрол эзэмших эрхтэй болдог асуудлыг арилгана гэж Сангийн сайд хэлсэн шүү дээ?

-2014 оноос хойш концессын гэрээ гэдэг цонхны цаанаас чихэр долоолгодог зүйл бий боллоо. Гэвч тэр гэрээг нь авсан компани ажил хийдэггүй байдал их. Харин Засгийн газар концессын гэрээгээр төчнөөн сургууль барьж байгаа л гээд байдаг. Ер нь хөгжлийн бодлогоо томоор харж, төсвөө ярьж баймаар байна. Тэгэхгүйгээр ард түмэнд, тойргийнхоо хүмүүст хайртай болж, жижиг сажиг зүйл ярьсаар байтал ард түмний амьдрал сайжрахгүй, ажилгүйдэл ядуурал буурахгүй байна. Тэгэхээр улсын хөгжлийн бодлоготой төсвөө

уялдуулах ёстой юм.

-Ажлын байр бий болсноор л иргэд ажилтай, орлоготой болно. Төсвийн төсөлд ажил олгогчид буюу бизнес эрхлэгч, хувийн хэвшлийнхнийг хэр дэмжсэн байна вэ?

-Манай гишүүд ажилгүйдэл, ядуурал гэхээр жижиг, дунд үйлдвэрт мөнгө тавьсангүй гэж хэлдэг. Үйлдвэрт зориулсан мөнгө гэж хэдэн жилийн өмнөөс овоо хэдэн төгрөг тавьсаар ирсэн. Гэвч жинхэнэ эзэндээ тэр мөнгө очдоггүй. Яагаад гэвэл, тэр зээлийг авах баталгаа, барьцааг жижиг дунд үйлдвэрлэгчид гаргаж чаддаггүй. Гэтэл тэр үйлдвэрийн эздэд оюун санаа, хөдөлмөрлөх чадавх, мэдлэг зүтгэл бол байдаг. Түүнээс гадна миний олон дахин хэлдэг зүйл нь 1990 оноос хойш Монгол Улс мэргэжилтэй боловсон хүчнээ бэлдээгүй. Тэдгээр сургуулийн тоног төхөөрөмж, бааз суурийг бэхжүүлэх ёстой.

Хэрэв мэргэжилтэй боловсон хүчин байвал ажлын байр нэмэгдэнэ. Дагаад татвар, нийгмийн даатгалын орлого өснө. Иргэдийн амьжиргаа сайжирна шүү дээ. Би саяхан барилгын салбарынхантай уулзсан. Хойд Солонгосын таван мянган ажилтныг МУ-аас гаргангуут барилгын салбарт савлагаа үүссэн гэж ярьж байна. Гуравхан сая хүн амтай Монголд ажилгүй, орлогогүй хүн маш их байхад Хойд Солонгосоос эсвэл 1.3 тэрбум хүн амтай Хятадаас ажиллах хүч авна гэдэг төрийн бодлого буруу явж байгаагийн илрэл. Жижиг, дунд үйлдвэрлэгчдээ зориулсан бодлого хэрэгжүүлээгүй, мэргэжилтэй боловсон хүчнээ бэлдэхгүй хаясны уршиг энэ юм.

-Өнөөдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд Валют зохицуулалтын тухай хуулийн төсөл байна. Энэ хуулийн төслийн хүрээнд олон талын байр суурийг улстөрч, эдийн засагчид илэрхийллээ. Та энэ төслийн талаар ямар бодолтой байна?

-Миний байр суурь маш тодорхой. Олон ч жил энэ асуудлыг ярьсан. Гадаадын томоохон хөрөнгө оруулагч нар “Танай улсын алт сайхан, зэсийн нөөц мундаг, нүүрсний коксжих чанар сайн” гэж хэлдэг л дээ. Гэсэн атлаа хөрөнгө оруулалтаа танай улсын банкаар шилжүүлэхгүй гэж байна. Гол шалтгаан нь Монголын банкуудад итгэхгүй, манай хөрөнгө оруулалт, орлого орж гарах хэмжээний түвшинд хүрээгүй гэдэг. Уучлаарай, та нар. Баялагт нь итгэж байгаа бол банкинд нь ч гэсэн итгэх ёстой.

-Монголын банкууд гадны томоохон хөрөнгө оруулагчдын гүйлгээг хийх хэмжээнд хүрээгүй тул төв банкаар гүйлгээг хийлгэнэ хэмээн ярьж байгаа гэж үү?

-Энэ бол аргаа барсан арга. Гэтэл хөрөнгө оруулалтын тогтворжуулалтын гэрээ гэх мэт дээр манай дарга нар дандаа гаднынханд бууж өгсөн, бөхөлзсөн, эрх ашигт нь нийцсэн заалт суулгачихсан. Монголын баялагт итгэж орж ирж байгаа бол валютаа Монголын банкаар дамжуулах ёстой гэдэг байр суурийг би баримталж байгаа.

-Тэр нь Монголбанк байхаар төсөлд суулгаж байгаа гэсэн үг үү?

-Уг нь Монголын арилжааны банкуудаар дамжуулах ёстой. Гэвч аргаа бараад төв банкаар дамжуулах хуулийн төслийг хэлэлцэж байна. Төв банкаар дамжуулах огт шаардлагагүй. Тиймээс би энэ хуулийн төсөлд өөрийн саналын томъёоллыг өгөхдөө “Арилжааны банкуудаар дамжуулъя” гэж бичнэ гэж бодож байгаа. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **ЦЭЦ**

УИХ-ын сонгуулийн 42 дугаар тойрог буюу Хэнтийн гурван суманд болох нөхөн сонгуулийг товчлосон УИХ-ын тогтоол “Үндсэн хууль зөрчсөн гэж” Цэц дүгнэсэн. Цэцийн дунд суудлын хуралдаанаас гаргасан уг дүгнэлтийг УИХ хүлээж авсангүй. Ингэснээр уг асуудал Үндсэн хуулийн цэцийн Их суудал руу шилжиж байна.

» **ХАРИЛЦАА**

БНФУ-аас Монгол Улсад суух Элчин сайдаар томилогдсон Ф.Мэрлинийг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн хүлээн авч уулзжээ. Энэ үеэр Монгол, Францын хамтын ажиллагааг Иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллахаа илэрхийлэв.

» **ТОО**

580

Мянган төгрөг. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн дундаж хэмжээ 580 мянган төгрөг аж. Энэ талаар цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэх үеэр ХНХ-ын сайд С.Чинзориг хэлэв.

эшлэл



Гэр хороолол дахь гэр бүр өөр радиустай байдаг. Мөн дулаалга бүр нь өөр. Тэнд стандарт гэх зүйл огт алга. Өнгөрсөн хугацаанд Солонгос, Германы эрдэмтдийг урьж хамтарч ажиллан, 200 гаруй гэрт судалгаа хийсэн. Судалгаанд хамрагдсан айлын гэр бүлд өөр радиустай, тэдгээр айл 18 төрлийн зуухыг хэрэглэж байна. Ямар ч стандартгүй байгаа учраас яндан дээр нь индукцийн шүүлтүүрийг нь тавья гэж санал нэгдсэн.Энэ жилийн хувьд айлуудыг дулаалгаа сайн хийж далайд дусал болно уу гэж хэлмээр байна.Утааны шүүлтүүрийг айлуудад үнэгүй тараана. Гэхдээ үндсэн үнийг төрөөс татаас хэлбэрээр төлнө.

БОАЖ-ын сайд
Н.Цэрэнбат

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжигатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал
» **INFO@ZASAG.CO**

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

ЗАСГИЙН ГАЗАР

Ази дахь зөвлөлдөх ардчиллын туршлагыг хэлэлцэж байна

Иргэд өөрсдөө асуудалд оролцоод, харьцуулж бодоод, жижиг бүлгээр хэлэлцэж, ухаж ойлгоод, ямар ч дарга, эрдэмтэн судлаачдаас илүү шийдвэр гаргадаг нь амьдралд нотлогдсон зүйл гэж ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар хэллээ.

Зөвлөлдөх ардчиллын энэ арга Азид их дэлгэрч байгаа гэж “Ази дахь зөвлөлдөх ардчиллын туршлага” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг нээж хэлсэн үгэндээ тэрбээр онцолсон юм.

Бага хуралд эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагын 120 гаруй



эрдэмтэн, судлаач, удирдах албан хаагчид болон гадаадын зочин илтгэгчид оролцож байна.

Монгол Улс 2017 оны хоёрдугаар сард зөвлөлдөх санал асуулгын тухай хууль батлан гаргасан нь Монгол Улсын төр, эрх зүй, Үндсэн хуулийн эрх зүйн

түүхэнд томоохон үйл явдлуудыг өрнүүлэх эхлэл болжээ.

Улмаар өнгөрсөн онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анх удаа зөвлөлдөх санал асуулгыг хоёр үе шаттайгаар зохион байгуулжээ. [ЗГМ]



Нийтлэлчийн булан

Хятадын импортын эрэлт нүүрсний экспортыг тодорхойлно

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM




Монгол Улс 2017 онд төсөвт төлөвлөсөн хэмжээнээсээ ахиу нүүрс зарж, нүүрсний экспорт түүхэндээ анх удаа 30 сая тонныг давж байлаа. Эрдсийн экспортыг хошуучилсан нүүрсний хэмжээ тэгэхэд биет жингээр 33.4 сая тоннд хүрч, орлого нь 2.2 орчим тэрбум ам.доллартай тэнцсэн удаатай. Тэгвэл энэ онд дээрх амжилтаа манай улс хадгалж, 32 сая тонныг экспортлох төлөв бий. Харин 2019 оны улсын төсвийн төсөлд Засгийн газар нүүрсний экспортыг 42 сая тоннд хүргэхээр тусгачихсан. Өөрөөр хэлбэл, нүүрснээс олох орлогоо тэр хэрээр өндөр тогтоочихсон гэсэн үг. Үүнийг эдийн засагчид төсвийн хэлэлцүүлэг өрнөж байгаа энэ үед янз бүрээр дүгнэж, боломжтой, боломжгүйн тухай ухаанаа уралдуулж байна.

Нүүрсний экспортын биет хэмжээ нэг жилийн дотор 10 сая тонноор нэмэгдэх боломжтой гэдэгт Сангийн сайд огтхон



С.Батсайхан / ЗГМ©

Төмөр замгүйгээр 42 сая тонныг экспортлох боломжтой юу



ч эргэлзэхгүй байгаа. Түүний “боосон” төсвийн орлого бүрдэхэд нүүрсний экспорт үлэмж үүрэг гүйцэтгэхээр буй. Гэхдээ байгаа нөөц, боломжоо тултал нь ашиглаад компаниуд жилд 30 сая тонныг БНХАУ-ын зах зээлд борлуулж байснаас 40 сая тонныг экспортолж байсан туршлага байхгүй. Энэ нь олон хүнд эргэлзээ үүсгэж, төсөвт нүүрсний экспортын хэмжээг бодит байдлаас хэт өөдрөг тооцоолсон гэсэн шүүмжлэл дагуулах болсон. “Гложекс консалтинг” компанийн Ерөнхий захирал Л.Наранбаатар төсөвт тусгасан 42 сая тонныг боломжтой гэж харж байгаа бол эдийн засагч Ч.Отгочулуу боломжгүй гэж үзсэн юм.

Монгол Улс оны эхний есөн сард 27 сая тонн нүүрс экспортлосон нь жилийн өмнөхөөс зургаан хувиар өсчээ. Нэг тонн нүүрсний дундаж ханш 16 хувиар нэмэгдэж, 78.5 ам.доллар болсон талаар Гаалийн

ерөнхий газар мэдээлсэн. Он дуусгах хүртэлх гурван сарын хугацаанд нэмж 5-6 сая тонн нүүрс экспортлох боломж байгаа юм. Учир нь, сард ойролцоогоор манай улс 1.8 орчим сая тонн нүүрс хилээр гаргаж байна. Ирэх оны төсөвт нэг тонн нүүрсний үүнийг 75.9 ам.доллараар тооцоолсон нь харин шүүмжлэлд өртсөнгүй. Гэхдээ Монголын нүүрсний экспортын хэмжээ Хятадын импортын нүүрсний эрэлт, хэрэгцээ болон дотоодын тээвэр, боомтын нэвтрэх хүчин чадлалд үндсэндээ захирагдаж ирсэн. Энэ нь бидний мөрөөдөж буй 42 сая тонныг экспортыг “чөдөрлөх” бодит тээг.

Манайх нүүрсний экспортоо нэмэгдүүлэхээр эрвийх дэрвийхээрээ чармайсан ч Хятадын нүүрсний импортын хэмжээ жилээс жилд хумигдаж, энэ зах зээл дэх өрсөлдөөн улам ширүүсэж буй. Өмнөд хөршийн импортын нүүрсний 40 орчим

хувийг өнгөрсөн онд манайх дангаар нийлүүлсэн ч цаашид улам нэмэгдүүлэхийн тулд төмөр замын тухай ярихаас аргагүй болж байна. Австрали, ОХУ-тай өрсөлдөхийн тулд тээвэрлэлтийн асуудлаа нэг мөр шийдэх хэрэгтэй байгаа. Одоогийн хүчин чадлаар нүүрсний экспорт 36 сая тонноос хэтрэхгүй гэдэг нь сүүлийн хоёр жилд тодорхой болж байна.

Компаниуд хил дээр хонон өнжин, цаг нартай уралдан байж 2017 оны амжилтыг бүтээсэн. Энэ онд ч энэ л янзаараа 30 сая тонноос давсан экспорт хийхээр байгаа юм. Харин 42 саяын экспорт гаалийн хяналтын шинэчлэл хийсэн ч ирэх онд бүрэн биелэх боломжгүй гэж эдийн засагч С.Болд үзэж байна. Зургаан боомтын нэвтрэх чадвар, хяналтыг манайх сайжруулж байгаа хэдий ч БНХАУ-ын Монголоос авах нүүрсний импортоо нэмэгдүүлэх эсэх нь тодорхой бус байгаа юм.

Дэлхийн банкны ахлах эдийн засагч Жон Паскаль “Хятадын талтай ямар зөвшилцөлд хүрэхээс Монголын нүүрсний экспорт хамаарна” гэж онцолсон.

Нүүрсний экспортын хэмжээг бодит байдлаас хэт өөдрөг тооцоолсон гэв

Хятадад нүүрсээ нийлүүлэх хүсэлтэй орнуудын “лобби” идэвхижиж байгаа энэ үед хөршийн бодол, санаа манай улсын төсвийн төлөвлөгөөг ч өөрчилж мэдэхээр байна. Тус улсын нүүрсний импортын зах зээлд ОХУ манай

улстай дөрөө харшуулах хэмжээнд томоохон өрсөлдөгч болон гарч ирсэн гэдгийг мартаж болохгүй. Коксжих нүүрсний импорт дунд хугацаанд Хятадаас Энэтхэг рүү шилжих хандлага ажиглагдах болсон. Тодруулбал, 2023 он гэхэд Хятадын импорт буурч, 57 сая тонн болох бол Японы импорт таван сая тонноор буурна гэж зарим судалгаанд дурджээ. Хятадын импорт аажмаар хумигдах төлөвтэй байгаа нь коксжих нүүрс олборлогч орнуудын өрсөлдөөн улам ширүүснэ гэсэн үг. 2019 оны төсвийн зорилт байгаа оноход хил дээрх гацаа ээлжит саадын нэг нь. Тухайлбал, Гашуунсухайтын боомтоор өдөрт 1250-1350 автомашин нүүрс ачин гарч байгаа ч цаг агаар болон Хятадын уламжлалт баяр экспорт саатах нэг том шалтгаан.

Хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадварыг сайжруулна гэж Засгийн

газрын төлөвлөсөн энэ ажлын дийлэнх нь 2019 онд хэрэгжихээр байгаа юм. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нүүрсний гол замд үүсдэг урт цувааг багасгах үүднээс Засгийн газар 320 дугаар тогтоол гарган богино зайн хэлбэрт шилжүүлсэн. Гэхдээ Монголын экспортын нүүрсний “цонх” нь зөвхөн Гашуунсухайт биш. Шивээхүүрэн болон Ховдын Булган, Бичигтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, Хятадын талын хяналт, шалгалтыг багасгах яриа хэлэлцээ шийдэл хүлээж байна.

Гашуунсухайтад 12 зам бүрт тусгай хяналтын кабин барьж ашиглалтад оруулснаар бичиг баримт шалгахад зарцуулдаг байсан гурван минутыг 50 секунд болгон бууруулсан. Үүнийг дээрх боомтуудад нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага бас байна. Нүүрсний экспортод тулгараад байгаа өөр нэгэн бэрхшээл нь захиргааны шаардлага буюу нэг машинд тавих хяналт ихэссэнтэй холбоотойгоор автомашинуудын нэвтрэлт буурсан гэж зарим компанийн захирал ярьсан юм. “Бид нүүрс экспортлох хүчин чадлынхаа 34 хувийг ашигладаг” гэж Л.Наранбаатар дурдсан. Монголтой хил залгаа Хятадын бүс нутгуудад коксжих нүүрсний хэрэглээ богино хугацаанд эрс өсөж байгаа боловч энэ зах зээл рүү тэмүүлсэн өрсөлдөөн цаашид ч хүчээ авахаар байна.

Засгийн газраас Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын ажлыг эрчимжүүлэхээр “Тавантолгой төмөр зам” компани байгуулсан. Цаасан дээр компани бий болж, уг төслийг цаашид хэрэгжүүлэхээр болсон ч ядахнаа нэг км төмөр зам шинээр баригдаагүй байгаа. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 орчим км урт төмөр зам ашиглалтад орсноор жилд 30 сая тонн нүүрс экспортод гаргах боломж бүрдэнэ гэж үзэж буй. “Эрдэнэс Тавантолгой”-н нэг тонн нүүрс төмөр замтай болбол тээвэрлэх өртөг найм орчим ам.доллараар буурах бөгөөд автозамын тээврээс дөрөв дахин бага зардлаар нүүрсээ өмнөд хөрш болон гуравдагч зах зээлд хүргэх боломж бүрдэхээр байгаа юм. Төсөл ирэх онд хэрэгжинэ гэсэн хүлээлт байна. Хэрэв уг төмөр зам ашиглалтад орчихсон байсан бол төсөвт тусгасан 42 сая тонн илүү боломжтой сонсогдох байсан биз ээ. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



Нийгэм



С.Батсайхан / ЗГМ©

Хадлан, тэжээлийн 70 хувийг базаагаад байна

Нийт нутгийн 40 шахам хувьд бэлчээрийн хүрэлцээ муу байна


С.Энэрэл
ЗГМ

Намрын сэрүү орж, нарны илч өдрөөс өдөрт буурч буй нь биднийг өвөлдөө бэлдэхийг сануулж буй дохио. Жил бүрийн өдийд малын тэжээлийн бэлтгэл, бэлчээрийн даацын хэмжээ, отор нүүдэл гээд түм буман асуудал босч ирдэг. Өнгөрсөн жил манай улсын малын тоо 66.2 сая болж, түүхэн дээд хэмжээндээ хүрсэн. Гэтэл энэ өвөл өмнөх жилийнхээс илүү хүйтэн, цас ихтэй жил болно гэсэн таамгийг ус, цаг уурын мэргэжилтнүүд гаргаад байгаа. Тиймээс хэдэн малаа турааж эцэрчихэлгүй, онд мэнд оруулах нь малчин бүрийн санаа зовох асуудал болоод буй.

ХХААХҮЯ-наас өгсөн мэдээллээр өвөлжилт, хаваржилтын бэлчээрийн даацын 60 гаруй хувь нь хэвийн байна. Харин 40 шахам хувьд нь бэлчээрийн хүрэлцээ муу байгаа тул өөр сумдын нутгаар отор нүүдэл хийх, тэжээл бэлтгэх шаардлага тулгарч байна.

Одоогоор Ховд, Баянхонгорын ихэнх, Говь-Алтай, Өвөрхангайн зарим сумдын нутгаар бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн тул өвөлжилт, хаваржилт хүндэрч болзошгүйг УЦОШГ-аас анхааруулав. Бэлчээрийн даац хэтэрсэн нутгийн тоонд Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Булган, Увсын Завхан, Малчин, Ховдын Эрдэнэбүрэн, Жаргалант, Ховд, Булган, Дуут, Зэрэг, Буянт, Мөст, Мянгад, Манхан, Чандмань, Дарви сум орж байна. Мөн Завхан аймгийн Эрдэнэхайрхан, Дөрвөлжин, Говь-Алтайн Дарви, Төгрөг, Тонхил, Халиун, Бигэр, Чандмань, Цогт, Тайшир, Баянхонгорын Хүрээмарал, Заг, Баянхонгор, Баацагаан, Баянцагаан, Баянговь, Баянлиг, Өлзийт, Жинст, Галуут, Бөмбөгөр сум болон Архангайн Хайрхан,

ЗГМ: ИНФОГРАФИК



Өгийнуур, Өвөрхангайн Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Богд, Гучин-Ус, Сант, Тарагт, Хэнтийн Дархан, Сүхбаатарын Уулбаян, Өмнөговийн Баяндалай сум орж байгаа аж. УЦОШГ-ын мэдээлснээр энэ өвөл дунджаар 3-5 мм цас орох бөгөөд цаг агаар өдөртөө 17-32 хэмийн хүйтэн байх төлөвтэй.

Өнгөрсөн зун ихэнх нутагт зуншлага оройтсон хэдий ч долдугаар сараас хойш хур тунадас их орсон тул бэлчээрийн

сэргэлтэд сайнаар нөлөөлжээ. Өмнөх онтой харьцуулахад зарим нутгийн бэлчээрийн даац 43 хүртэл хувиар нэмэгдсэн болохыг мэдээлэв. Үүнтэй холбоотойгоор аймаг дундын отрын бүсүүдэд хонин толгойд шилжүүлснээр 700 мянган толгой мал өвөлжүүлэх боломжтой хэмээн дүгнэжээ.

Монгол Улсын Засгийн газраас мал сүргийг байгалийн гэнэтийн болон давагдашгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах

зорилгоор нийт 783.3 мянган га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, есөн аймагт дундын отрын бүс байгуулсан байна. Эдгээр отрын бүсийн өвөлжилтийн бэлтгэл ажлын явцтай Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, ХХААХҮ-ийн сайд Б.Батзориг, УИХ-ын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Л.Элдэв-Очир танилцжээ. Аравдугаар сарын 7-ны байдлаар улсын хэмжээнд 895.9 мянган тонн өвс, 353.1 мянган тонн сүрэл, 21.5 мянган тонн ногоон тэжээл, 1.4 мянган тонн үйлдвэрийн тэжээл, 30.9 мянган тонн гар тэжээл, 1.8 мянган тонн дарш, 29.3 мянган тонн давс, хужир бэлтгэлээ. Энэ нь хадлан, тэжээлийн 70 хувийг бэлдсэн гэсэн үг. Бэлтгэл ажлыг аймгаар нь авч үзвэл, Архангай, Баян-Өлгий, Булган, Орхон, Ховд, Хөвсгөл аймагт 80-аас дээш хувийн биелэлттэй байгаа аж. Засгийн газрын зүгээс аймаг, сумдын аюулгүйн нөөцөд одоогоор 7.8 мянган тонн өвс, 2.1 мянган тонн тэжээл тус тус бэлтгэсэн талаар албаныхан мэдээлэв. [ЗГМ]

ТОВЧХОН

» ХАМТЫН АЖИЛЛАГАА

Малчид нэгдэн бүлэг болж, малын хулгайтай тэмцэх ажлыг эхлүүлээд байна. Зөвхөн Төв аймагт гэхэд энэ ажлын хүрээнд малын хулгайг 15 хувиар бууруулж чаджээ.

» ШИЙДЭЛ

Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж эхэллээ. 2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөгөөр бол нийслэл Бага тойруу, Яармаг гэсэн хоёр төвтэй байх юм. Мөн Сэлбэ, Баянхошуу, Дамбадаржаа, Сонсголон, Амгалан гэх мэт найман дэд төвийг бий болгохоор төлөвлөжээ.

» ХӨНГӨЛӨЛТ

Цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлт арваннэгдүгээр сарын 1-нээс гуравдугаар сарын 31-нийг хүртэл үргэлжлэх бөгөөд гэр хорооллын бүсэд орших хоёр тарифт тоолууртай өрхүүд 21:00-06:00 цагийн хооронд хөнгөлөлттэй үнээр цахилгаан хэрэглэх юм. Энэ жил 154 мянган өрх өвлийн улиралд шөнө хэрэглэсэн цахилгааны төлбөрөө 50-100 хувь хөнгөлүүлэх урьдчилсан тооцоо гарчээ.

» САНААЧИЛГА

Худалдаа хөгжлийн банк 28 жилийн ойгоо угтан ерөнхий боловсролын 28 сургуулийн номын санг тохижуулах аяныг эхлүүлсэн. Үүний хүрээнд Баянгол дүүргийн 24 дүгээр сургууль болон Дархан-Уул аймгийн 9 дүгээр сургуулийн номын санг тохижуулж, хүлээлгэн өглөө.

» ХЯНАЛТ

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас хууль бус үр хөндлөтийг таслан зогсоох, нийтэд сэрэмжлүүлэх чиглэлээр шалгалт хийжээ. Уг шалгалтад нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 46 эмнэлэг хамрагдсан байна. Шалгалтын үеэр “Цэцэнгуа”, “Цэцэгс”, “Баянхан гүнж” эмнэлгийн эмч нар эмчлэх, сувилах, эх барих зөвшөөрлөгийгээр ажиллаж байсан нь илэрчээ.

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба


ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Бло Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР
zgm.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
З.Цэлмэг


865800042912 001000



Millennium Challenge Account (MCA) – Mongolia

Closing Date: 17.00 ULAT, October 26, 2018

About MCA-Mongolia

The Government of Mongolia (“Government”) seeks qualified individuals to help organize, manage and lead a new special purpose entity to be known as the Millennium Challenge Account – Mongolia (“MCA-Mongolia”). The Government will shortly establish MCA-Mongolia in the form of a state-owned enterprise to oversee the implementation of the Mongolia Water Compact (the “Compact”), a major international development assistance program funded by the Millennium Challenge Corporation (“MCC”), a United States Government agency that provides grant assistance to help partner countries promote economic growth and reduce poverty.

The Compact aims to increase the long-term sustainable supply of water to Ulaanbaatar and stem the impact of an impending water crisis. The Compact will expand the supply of water to residential consumers and commercial and industrial users in Ulaanbaatar through:

- The construction of new groundwater wells downstream from Ulaanbaatar and introduction of a state-of-the-art water purification plant;
- The construction of a new freshwater recycling plant and pipelines to provide high-quality treated freshwater;
- Policy reforms, capacity building, and technical assistance to improve the long-term sustainability of Ulaanbaatar’s water supply.

MCA-Mongolia will oversee the implementation of these investments on behalf of the Government and in compliance with the guidelines and standards of MCC.

The Roles DIRECTOR, LEGAL (GENERAL COUNSEL)

Main Tasks: The General Counsel serves as the principal legal capacity for the management team and the Board of Directors of MCA-Mongolia. In this capacity, the General Counsel develops and provides policy advice and opinions on a wide range of legal matters. The General Counsel also serves as the corporate secretary to the Board of MCA-Mongolia. The General Counsel reports to the Chief Executive Officer (CEO) and manages one dedicated, full-time staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7696>

DIRECTOR, DOWNSTREAM WELLS

Main Tasks: The Director, Downstream Wells, manages the preparation and implementation of the Downstream Wells Activity, including the finalization, review; and approval of detailed designs; the development of work plans and risk mitigation strategies; the preparation of detailed procurement documents; and the implementation of complex construction works under tight budget and timeline constraints. The Director, Downstream Wells, also oversees portions of the Water Sector Sustainability Activity that involve small scale works in the ger areas of Ulaanbaatar. In the course of these responsibilities, the Director, Downstream Wells, works closely with design consultants, works contractors, a variety of implementing entities, and a program management consultant. The Director, Downstream Wells, reports to the Deputy Chief Executive Officer, Programs (the “Deputy CEO”), and manages three dedicated, full-time staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7699>

DIRECTOR, SUSTAINABILITY

Main Tasks: The Director, Sustainability, coordinates and manages support for policy, legal, regulatory and institutional changes that enhance the long-term sustainability of the water supply system in Ulaanbaatar, including the development and implementation of assessments, technical assistance and capacity building efforts in public entities at the local, municipal and national levels. The Director, Sustainability, establishes, communicates, and reinforces a common vision of change and coordinates the development of activity designs; the completion of bidding documents for all necessary procurements; the drafting of work plans and risk mitigation strategies; and the implementation of various activities. In the course of these responsibilities, the Director, Sustainability, works closely with the Director, Downstream Wells, to ensure the proper implementation of small-scale works in the ger areas of Ulaanbaatar and with other members of the Program Division staff. The Director, Sustainability, reports to the Deputy Chief Executive Officer, Programs (the “Deputy CEO”), and manages one dedicated, full-time staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7701>

DIRECTOR, COMMUNICATIONS

Main Tasks: The Director, Communications, leads and manages communications efforts related to the compact program, including media outreach, press placement and coverage, public information campaigns, and publicity events. In the course of these responsibilities, the Director, Communications, works closely with the Director, Environmental and Social Performance, to enhance stakeholder engagement activities and with the Director, Sustainability, to amplify public awareness and behavior change efforts related to public perceptions of water. The Director, Communications, builds strong relationships with the media, cultivates media opportunities for MCA-Mongolia officials, develops and implements a robust communications strategy, and serves as the official spokesperson for MCA-Mongolia. The Director, Communications, reports to the Chief Executive Officer (CEO) and manages two dedicated, full-time staff.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7706>

MANAGER, INFORMATION TECHNOLOGY

Main Tasks: The Manager, Information Technology, is responsible for the delivery and implementation of IT-related services to include network management and data infrastructure oversight, ensuring that services rendered support the work of the MCA. The Manager, Information Technology, reports to the Director, Administration, and supervises one dedicated staff member.

To review a comprehensive job description or to apply for this position please visit <http://www.sri-executive.com/offer/?id=7709>

We are encouraging all interested parties to apply for the role. Selection process will be based on merit on the required experiences for all vacancies. Qualified applicants will receive consideration for employment without regard to race, ethnicity, religion, sex, national origin, or disability. No fees will be paid to MCA- Mongolia or any of its agents at any stage of the recruitment process (application, interview, processing, training fees or other).

SRI Executive (www.sri-executive.com) is assisting the Government of Mongolia in its search for exceptional candidates for MCA-Mongolia. SRI Executive operates under a contract provided by MCC. SRI Executive is supported by our local partner Specialized Career Consulting (SCC) in this recruitment initiative.



Үзэл бодол

ӨДӨР ТУТМЫН СОНИНУУДЫН ФОРУМ 2018

Төр “За” гэхийн оронд “За, яах вэ” гэж хандаж байна

Хүүхэд харах үйлчилгээний төсвийг 1.9 тэрбум төгрөгөөр бууруулж, дахин 2070 хүүхэд гэртээ үлдэнэ

«1 Гэвч ирэх жил төр хүүхдүүдээс гар татаж, уг үйлчилгээний төсвийг 1.9 тэрбум төгрөгөөр хасчээ. Ингэснээр 2070 хүүхэд шууд хасагдах нөхцөл бүрдэв. Та бүхэн энэ хүүхдүүдийг хаашаа оч гэв ээ. Хэрэгжиж эхлээд хоёр дахь жилийнхээ нүүрийг үзэж буй энэ үйлчилгээний ач холбогдол ийм хурдан сарних юм гэж хэн төсөөлөх билээ. Шинэ тутам хөгжиж буй тус салбарт ч төсвийн энэ таналт том цохилт болж байна. Төрийн үүргээс үүрэлцэхийн зэрэгцээ, 1000 гаруй хүнийг ажлын байраар хангаж буйг нь үл тоолоо гэхэд хүүхэд хамгааллын бодлого хаачих вэ. Олон мянган эцэг, эх хүүхдэдээ уягдан гэрийн “хорионд” орж өрхийн амьжиргаа нь буурсаар байгааг арчаагүй төрийн алагчилсан бодлого гээд орхиё. Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын талаар төрийн тэргүүнээс эхлээд Өдөр тутмын сонины холбоо, хэвлэл мэдээлэл хангалттай халаглаж, харамссаар атал бодлого боловсруулагч, төсөв тооцоологчид сэтгэлгүй хандаж байна. 1994 оноос Монголд үйл ажиллагаа явуулж буй Хүүхдийг Ивээх Сангаас Засгийн газарт хүүхдийн төлөө зориулах төсөв, хөрөнгөө нэмэгдүүлж, ялгаатай орлоготой, амьдралын чанар нь өөр орчинд амьдарч буй бүх хүүхдийг эсэн мэнд амьдрах тэгш боломжоор хангах ёстой гэсэн зөвлөмж өгдөг. Өнгөтэй, өөдтэй бүхнээ хүүхдэд зориулж, ирээдүйн иргэдээ хамгаалах үүргийг өрх гэр төдийгүй бусад улс орон ягштал баримталдаг байхад манай төрийн түшээд өөрсдийнхөө эрх ашгийн төлөө хүүхэд хамгааллыг “За яах вэ” гээд орхиж байна. Энэ жилийн төсөвт гишүүн бүрт таван тэрбум төгрөгийн лимит олгож тойрогтоо зарцуул хэмээн “баантаглаж” буй тухай мэдээ төрийн ордноос



ГССҮТ-д ахуйн түлэгдэлтээр 4059 үйлчлүүлэгч яаралтай тусламж авсны 62.2 хувь буюу 2525 нь 0-5 хүртэлх насны хүүхэд байна. Тав хүртэлх насны хүүхдийн нас баралтын 14.4 хувийг ахуйн түлэгдэлт эзэлж байгаа бөгөөд 77 хувь нь халуун хоол цайнд, 23 хувь халуун усанд түлэгджээ.

С.Батсайхан / ЗГМ©

дууддаж эхэллээ. Ашиг сонирхол хангалсан энэ төсвийг жаалуудаас харамлаж, жалга довны зүйлд зарлагадсан гэж хардахаас өөр арга алга. Нөгөө “Хүүхдийн төлөө За гэж хэлье” гэдэг тунхаг бүр цаашлан одлоо.

Өнгөрсөн хугацаанд хүүхэд харах үйлчилгээнд 11.8 мянган хүүхэд хамрагджээ

2018 оны төсөвт Хүүхэд хамгааллын үйлчилгээний зорилтот түвшнийг нийт хүүхдийн 3.5 хувь байхаар тогтоож байжээ. Ирэх жил энэ тоог 4.5 хувьд хүргэнэ гэж

дэвшүүлсэн байх юм. Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны төсвөөс дөрвөн тэрбумыг хасаж, Хүүхэд харах үйлчилгээний мөнгийг бараг хоёр тэрбумаар бууруулчихаад хөөрцөглөөд байгааг ойлгохгүй байна. Сангийн яамныхан 2019 онд 143 цэцэрлэгийн шинэ барилгын ажилд 144.4 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөснөө “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр бараг биеллээ гэж хөөрцөглөж байгаа бололтой. Энэ ажил 2020 онд бүрэн биеллээ олох боломжтой гэдэг нь манай орны нөхцөл, төрийн үйл ажиллагааны хурдаас илэрхий шүү дээ. Гайхамшигийг үзүүлж ашиглалтад орлоо гэхэд бүх хүүхдийг хамарч чадна гэдэг юу л бол. Нөгөөтэйгүүр, тэр болтол хүүхдийн аюулгүй байдлыг зохиослох эрх төрд бий гэж үү. Харах хүнгүйгээс, эсвэл гэртээ цоожлогдсон айлд тавиул болсон хүүхдүүд түлэгдэж,

шатаж амь насаа алдсан эмгэнэлт явдал тасрахгүй байна. Ахуйн осол гэмтэлд өртөх хүүхдийн тоо ч буураагүй. Цэцэрлэгт хамрагдаж чадаагүй бага насны хүүхдүүд голдуу сургуулийн насны ах, эгчийн мэдэлд үлддэг нь Монголын нийтлэг дүр зураг. Хүүхэд л хойно анхаарал, сэрэмж алддаг. Утас, телевизэд хэтэрхий автсанаас бага насны хүүхдээ халуун тогоонд үйчихсэн хариуцлагагүй эцэг эх олон байхад дүүгээ харж үлдсэн хүүхдүүд гэнэдэх нь аргагүй. ГССҮТ-д ахуйн түлэгдэлтээр 4059 хүн яаралтай тусламж авсны 62.2 хувь буюу 2525 нь 0-5 хүртэлх насны хүүхэд байна. Тоон мэдээгээр тав хүртэлх насны хүүхдийн нийт нас баралтын 14.4 хувийг ахуйн түлэгдэлт эзэлж байгаа бөгөөд 77 хувь нь халуун хоол цайнд, 23 хувь халуун усанд түлэгдсэн байжээ. Үүнээс гадна цонх, тагтнаас хүүхэд унаж нас

ЗГМ: ИНФОГРАФИК



барсан тохиолдол энэ онд гэхэд л арав гаруй бүртгэгджээ. Урьдчилан сэргийлж болох шалтгаанаар эндэж байгаа хүүхдийн тоо дэлхийн хэмжээнд 1990 онд 12 сая байсан бол 2016 оны байдлаар 4.2 сая болон буурчээ. Энэ нь хүүхэд хамгааллын чиглэлээр хөрөнгө мөнгө, идэвх санаачилга харамгүй гаргасны үр дүн. Гэтэл манай улс сургуулийн өмнөх насны хүүхдийн ахуйн эндэгдлээс салаагүй л байна. Үүнд чухал нөлөө үзүүлж байсан Хүүхэд харах үйлчилгээг төрөөс хавчиж эхэлсэн нь тоон үзүүлэлтийг нэмж ч мэднэ. Энэ сарын 23-нд 0-5 насны хүүхдийн эсэн мэнд амьдрах, аюул эрсдэлгүй орчинд өсч бойжих олон улсын эрхийн өдөр тохионо. Монголчууд энэ өдрийг төр нь бодлогоосоо буцсан, төсөв нь мөнгөө харамласан байдалтай угтах нь. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН

IV улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна

ОНЛАЙН ЗАХИАЛГА

Улиралд: 5000₮ (62 дугаар)
Хагас жилд: 10000₮ (124 дугаар)
Жилд: 15000₮ (248 дугаар)

ХЭВЛЭМЭЛ ЗАХИАЛГА

Нэмэлт: 21000₮ (46 дугаар)
Хагас жилд: 60000₮ (124 дугаар)
Жилд: 120000₮ (248 дугаар)

ХОСОЛМОЛ ЗАХИАЛГА

(Хэвлэмэл + Онлайн)
Улиралд: 32000₮ (62 дугаар)
Хагас жилд: 65000₮ (124 дугаар)
Жилд: 125000₮ (248 дугаар)

Та QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт [и-мэйл хаяг](#) эсвэл [утасны дугаараа](#) бүртгүүлэн Засгийн газрын мэдээ сониныг өөрийн хүссэн хэлбэрээрээ захиалаарай.

QR код ашиглахгүйгээр төлбөр хийх бол:

2600092954
тоот дансанд мөнгөө тушаана уу.

zgm.mn

ZGMmn

zasagco

zgm.mn

70103131 99903581

ZGM DAILY

Law on Currency Regulation allows BoM to limit FX withdrawal

Economists warn fx control will reduce investment.

Coal export grows 6 percent month over month in September

Around 1250-1350 trucks entered Gashuunsukhait port in September.

Parliament approves project on Solid Waste Disposal Facility

EBRD announced to grant EUR 4.5 million aid for the facility

Government reaches deal with OT on power plant issue

Sides are yet to settle tax act, which may go to arbitration.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

The newly-appointed Ambassador Extraordinary and Plenipotentiary of France to Mongolia, Mr. Philippe Merlin, presents his credentials to President of Mongolia Battulga Khaltmaa.

Prime Minister Khurelsukh Ukhnaa receives Abdullah Abdul Rahman Al Tunaiji, Ambassador Extraordinary and Plenipotentiary of the United Arab Emirates to Mongolia. PM noted the possibility to continue cooperation with the Abu Dhabi Fund for Development and investment opportunities in infrastructure, road construction, mining, energy and agriculture of Mongolia.

Minister for Foreign Affairs of Mongolia Tsogtbaatar Damdin is visiting United Kingdom on October 10-12 to participate in the "Illegal Wildlife Trade" international conference organized by the British government. During his visit to the UK, Minister Tsogtbaatar met with Mr. Julian Knight, the UK Prime Minister's Trade Envoy to Mongolia.

ECONOMY

Officials estimate zinc production to reach 16.8 million tons by 2027.

Involving over 20 Czech entities operating in wastewater treatment, machinery, equipment, agricultural machinery, banks, transport and freight forwarding sectors, Mongolia-Czech Business Forum kicks-off in Mongolia.

Top 20 Index falls 0.2 percent, to 20,434.38 points. MSE A Index drops 0.4 percent, to 9,779.88 points. MSE B Index grows 0.05 percent, to 8,847.96 points. Market cap stands at MNT 2.4 trillion.

SOCIETY

Kimunyoung 2018 Mongolia Open International Taekwondo Championships to take place on October 20-21 at the Olympics complex in Khandgait, Ulaanbaatar. Athletes from more than 10 countries including South Korea, Japan, Russia, China, Kazakhstan, Uzbekistan and Thailand have submitted their applications to participate in the event to be held in three age categories across individual and team competitions.



Batsaikhan.S / ZGM©

Mongolia's foreign exchange reserves should cover 1-year of average import purchase, as required by the EFF.

BoM may restrict FX withdrawal if Parliament passes bill on currency

Law on Currency Regulation will allow BoM to control FX flow

Tugsbilig.B
@tugsbiligZGM

The Bank of Mongolia (BoM) included an article that can allow the bank to temporarily restrict withdrawal and transfer of for-

eign exchange on the draft Law on Currency Regulation, which was passed by the Parliamentary Standing Committee on Economy. BoM explains the article is aimed at maintaining financial stability and reduce dollarization as trade deficit pressures the currency rate. Furthermore, it will allow the bank to control currency rate during sharp volatility. In the first eight months of 2018, the balance of payment totalled USD 361 million in deficit. Within the frames of the International Monetary Fund's Extended Fund Facility arrangement, Mon-

golia agreed to have a foreign exchange (FX) reserves of 1-year of average import purchase.


Foreign exchange control will reduce investment, warn economists

Officials highlighted that Mongolia's current FX reserves can cover six months of import purchase.

The BoM set a goal to continue the reform in banking and financial sectors on the 2019 Monetary Policy Guidelines. Thus, several bills will be prepared within the frame. For instance, the bills on Financial Consumer Protection, Development of Secondary Market for Asset Management and Improvement of Legal Regulation of Treasury. The economist club of Bloomberg TV Mongolia highlighted that the Government's control on fx in and outflow has a negative effect of reducing investment. On the contrary, the BoM views the draft

Law on Currency Regulation will reduce FX risks. "The flexibility of currency rate will help protect the economy from foreign shock and boost export competitiveness," highlighted the Governor of BoM Bayartsaikhan Nadmid. Furthermore, the bill on Financial Consumer Protection will be a strong impetus in reducing interest rate. The bank explained that the lack of identification of financial consumer brought them into an uncertain situation, ultimately harming their rights. The Parliament is expected to discuss the bill soon. [ZGM]

FX MARKET



MINING

27 million tons of coal exported in 2018

Mongolia exported a total of 27 million tons of coal in the first nine months, which is a 6 percent annual growth. The price of coal jumped by around 16 percent, to USD 78.5 per ton according to the customs. The Ministry of Finance planned to export 42 million tons of coal in the draft of 2019 State Budget. Finance Minister Khurelbaatar Chimed explained that the amount can be achieved by reforming border inspections. As of today, capacity expansion of six border checkpoints are currently underway. The capacity of Gashuunsukhait border checkpoint drastically improved since September, to around 1250-1350 coal trucks per day, informs Bold Tsegmed, Executive Director of Gashuun Sukhait Road LLC. Nearly 14 million tons of coal was transported through this checkpoint since January. [ZGM]

POLITICS

Solid Waste Recycling Plant to be established near Chinggis Khaan Airport



Parliament approved the Law on Ratification of the 1907 Treaty for the Pacific Settlement of International Disputes and the Development of Solid Waste Disposal Facility in Ulaanbaatar project during its plenary session yesterday. On the approval of pacific settlement treaty, Minister of Justice and Home Affairs Nyamdorj Tsend addressed, "The approval of the

agreement will allow Mongolia to receive the financial aid of arbitration and settle disputes at lower cost. Also, the Permanent Court of Arbitration organizes capacity building workshops for public servants, lawyers, related officials and helps the member countries to improve the investment climate and legislation. The Cabinet considered that it is wise to join the treaty now

that investment and foreign trade of Mongolia is expanding." Later on, the Parliament members discussed and approved the Agreement between the Government of Mongolia and European Bank for Reconstruction and Development (EBRD) on the Development of Solid Waste Disposal Facility in Ulaanbaatar project. Officials highlighted that the project will quadruple the capacity of waste collection, transportation, recycling and disposal services, as well as dumpsites. EBRD announced to grant EUR 4.5 million in a non-refundable aid and USD 9.7 million in a soft loan for the project. The loan has a maturity period of 15 years and 3-years of moratorium. The working group responsible for the project highlighted that they are planning to establish a solid waste recycling plant near the Chinggis Khaan International Airport with the EBRD financing. [ZGM]

ENERGY

Zandanshatar.G: Govt and OT agree on power station deal



Chief of Cabinet Secretariat Zandanshatar Gombojav announces that the Government reached a deal with Oyu Tolgoi LLC on the electricity issue. As negotiated on the Investment Agreement, OT should draw electricity from domestic sources within four years after operation. However, OT has been importing USD 150 million worth electricity from abroad annually. Armando Torres, CEO of OT, previously noted that the board approved the necessary investment to study the electricity-issue. As a reminder, the Minister of Energy Davaasuren Tserenpil has said the Government will issue a demand to draw electricity from

domestic power network starting from January 2019. Furthermore, OT received USD 150 million tax act and acknowledged USD 35 million. According to Mr. Zandanshatar, sides could not find common grounds on the issue and noted "The remainder can be resolved through the court of arbitration." As for the investment agreement, several talks were held between the Government and OT this year to improve the agreement. Chief of Cabinet Secretariat highlighted that the sides agreed on five key principles, such as to expedite the dividend generating period for Mongolia and reduce interest pressure on Mongolia. Following the announcement, Rio Tinto Group's stock price fell 3.23 percent, to AUD 76.6 per share at the ASX, while Turquoise Hill Resources' stock price dropped 2.3 percent, to CAD 2.55 at the TSX as of yesterday. [ZGM]

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 09:00 “Өөдрөг залуус” ОАУСК 3 дугаар анги
- 11.00 “Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөр (шууд)
- 14.55 Өв эрдэнэ: Шармал цэцэг
- 17.25 Эх өв: Дуутай хуруу
- 19.30 “Туршлагад хил хязгаар үгүй” сурвалжлага
- 21.25 Монголын түүх: Кидан



- 07.00 "Суутнуудын намтар" нэвтрүүлэг
- 11.00 "#MadelnMongolia" нэвтрүүлэг
- 14.00 "Дэвид Рубенштэйний шоу" нэвтрүүлэг
- 17.00 "Bloomberg Surveillance"
- 20.00 "Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг
- 23.00 "Мөнгөний урсгал" давталт


БОЛОВСРОЛ

- 07.20 "Бяцхан оцон шувуу Пороро" 2-25-32 дугаар анги
- 10.05 "Яг чам шиг охин" ОАК 71, 72 дугаар анги
- 13.05 "Кино миний амьдрал" нэвтрүүлэг
- 15.50 "Аугаа уран зургууд" нэвтрүүлэг
- 18.05 "Тобот" 2-17, 18 дугаар анги
- 21.15 "Мөрөөдлийн баг дэлхийг аварна" шоу тоглолт



- 06.30 "Тог тог тог" /season-6/ 13 дугаар хэсэг
- 10.30 "Муу залуус-2" СОАК 10 дугаар анги
- 12.30 Монгол тулгатны 100 эрхэм-Б.Бат-Эрдэнэ
- 16.30 "Хагацашгүй дурлал" СОАК 13,14 дүгээр анги
- 18.30 "Хүүхдийн ертөнц" 20 дугаар анги
- 21.00 "Ороод гараач" /season-2/ 16 дугаар анги

ЗУРХАЙ




Билгийн тооллын 3
Намрын адаг хар нохой сарын есөн улаан мэнгэтэй, улаагчин үхэр өдөр **Үс засуулбал:** Эд мал баялаг төгөлдөр болно.
Наран ургах, шингэх: 07.07-18.11
Барилдлага: Шид
Шүтэн барилдлага: Өтлөх үхэхүй
Суудал: Уул

Аргын тооллын аравдугаар сарын 12, Сугар гараг. Билгийн тооллын 3, Онгоц одтой. улаагчин үхэр өдөр.
Өдрийн наран 07.07 цагт мандаж, 13.11 цагт жаргана. Тухайн өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, зэрэг дэвших, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Эрдэнийг гадагш өгөхөд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Балжинням, Дашнямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд малтай баялаг төгс болно.

ОНЦЛОХ ҮЗВЭР

“Гамлет” монодрам



Аугаа У.Шикспирийн эмгэнэлт бөгөөд сонгодог бүтээл болох “Гамлет” жүжгийг монодрам хэлбэрээр толилуулах гэж байна. Ерөнхий найруулагчаар С.Баасанжаргал ажилласан бол Гамлетийн дүрийг Л.Эрдэнэ-Очир бүтээжээ. Монодрам хэлбэрээр гурав дахь удаагаа тайзнаа амилж буй уг бүтээл дээр 20 орчим хүний бүрэлдэхүүнтэй Green entertainment-ийн уран бүтээлчид ажиллаж буй аж. Тоглолт энэ сарын 24, 25-нд 20.00 цагаас Corporate Convention Centre-д болох бөгөөд тасалбарын үнэ 80 ба 100 мянган төгрөг юм байна. [ЗГМ]



П.И.Чайковскийн “Хунт нуур” балет
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2018.10.14-нд 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 10-30 мянга




Б.Шаравын “Чингис хаан” дуурь
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2018.10.26-27-нд 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 10-20 мянга



“Шопен ба Шарав” төгөлдөр хуурын сонгодог
Хаана: Чингис хаан зочид буудал
Хэзээ: 2018.11.03-нд 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 50-60 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



- (товчилсон нэр)
12. Өгүүлбэрийн төгсгөлд тавих тэмдэг
13. Хүн амьтны өнгө
- мөрөн гол
11. Цагаан идээ
13. Чингис хааны ууган хүү
14. Альт хоолойн монгол нэр
15. Аргал түүх сав
16. Өвлийн олимпийн наадмыг зохион явуулсан ОХУ-ын анхны хот

Өмнөх дугаарын хариу / 10.11

ХӨНДЛӨНГӨӨР:

1. Дэлхийг тойрсон явган аялагчидтай цуг явж эр зориг, хүч чадлаараа гайхагдсан амьтан
6. Нэгэн зүйл зэрлэг үхэр
8. Хамгийн том арлыг эзэмшдэг улс
10. ОХУ-ын нутгаар урсдаг



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

Х.13 14° 7 м/с 0° 5 м/с Багавтар үүлтэй	Х.14 11° 6 м/с -2° 5 м/с Үүлшинэ	Х.15 13° 6 м/с 0° 5 м/с Багавтар үүлтэй	Х.16 12° 6 м/с -0° 5 м/с Багавтар үүлтэй	Х.17 9° 6 м/с 1° 5 м/с Багавтар үүлтэй
---	--	---	--	--






ФОТО АГШИН



Намрын адаг сарын шинийн 03 бол хос хоёрын хайр сэтгэлийн баталгаа болдог сүүн цагаан хуримд ээлтэй өдрүүдийн нэг.

Б.Хасуй / ЗГМӨ

ЗГМ: СҮДОКУ



(Анхны нийдэглэл хөнгө)



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	06.10	08.25
БЭЭЖИН-УБ	09.30	12.00
УБ-СӨҮЛ	08.20	12.30
СӨҮЛ-УБ	14.20	17.00
УБ-ТОКИО	07.45	13.40
ТОКИО-УБ	14.40	19.15
УБ-ЭРХҮҮ	07.50	09.15
ЭРХҮҮ-УБ	10.15	11.45
УБ-ХӨХ ХОТ	13.10	15.50
ХӨХ ХОТ-УБ	16.50	19.20
УБ-МӨРӨН	13.30	15.00
МӨРӨН-УБ	15.30	16.50

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Бөс даавуу, бэлэн хувцас үйлдвэрлэлээр тэргүүлэх Вьетнамын амбийц

Вьетнамын экспортын ихэнхийг нэмүү өртгийн багагүй татвар шингэсэн импортын даавуугаар хийсэн бүтээгдэхүүн эзэлдэг. > 10



Ирээдүйн төлөөх Toyota, Softbank-ны түншлэл

Toyota компани автомат жолоодлогот автомашины төрөл бүрийн үйлчилгээнд Softbank-тай хамтран ажиллахаар боллоо. > 10



Долоо хоног үргэлжилсэн бүх нийтийн амралтын дараа Хятадын төв банкнаас эдийн засгаа дэмжихээр дотоодын хөрөнгийн биржийн уруудсан нөхцөлийг өөд татахаар авсан арга хэмжээний найдвар замхарлаа. Shanghai Composite индекс даваа гарагт дөрөв орчим хувиар унасан нь сүүлийн дөрвөн сарын үнэмлэхүй уналт болсон юм.

Хятадын Ардын Банкны (ХАБ) өнөөгийн гол бодлогод хувьцааны үнэ дэмжих заалт байхгүй. Харин валютын ханш болон бодлогын хүүг тогтвортой хадгалах үүрэг хүлээдэг. Гэтэл сүүлийн хэдэн сар дотоод, гадаад дарамтын улмаас ийм тэнцвэржүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх нь мөнгөний зохицуулах байгууллагад хүнд болж хувирлаа.

ХАБ юанийн ханшийг хамгаалахаар оролдож, дотоодын эдийн засгаа эрс удаашруулах эрсдэлд оруулахын оронд аясаараа сулрахыг зөвшөөрнө хэмээн таамаглаж байна. Дональд Трампын хувьд энэ нь Хятад улс экспортлогчдыг дэмжих зорилгоор валютын ханшаа эзвэг болгосон хэрэг болж мэдэх ч үнэндээ мөнгөний зөөлөн бодлогын дам нөлөө юм.

ХАБ банкуудын нөөцийн хэмжээг дөрөв дэх удаагаа бууруулах шийдвэрийг энэ долоо хоногт гаргасан. Уг шийдвэр хүчин төгөлдөр болох аравдугаар сарын 15-нд 750 тэрбум орчим юань (108 тэрбум ам.доллар) арилжааны банкны нөөцөд шилжин гадагшилж мөнгөний тогтолцоонд эргэн нийлнэ.



Хятад улс юанийн ханшийг зөнд нь орхихоор шийдлээ

Уг арга хэмжээ эдийн засагт шууд хөшүүрэг болох зорилгогүйг ХАБ тайлбарласан. Гэхдээ Засгийн газрын хэмнэлтийн бодлого, хурцдсаар буй гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр эдийн засаг хүндэрсэн нөхцөлд жижиг, хувийн аж ахуйд дэм болохын зэрэгцээ найдваргүй зээлийн хэмжээг хянахад тусгай хэмээн үзэж байна.

Банкны нөөцийн хэмжээг цаашид ч бууруулахаар төлөвлөж байгаа. Энэ удаагийн зохи-

цуулалтаар БНХАУ-ын гол том банкуудын нөөцийн хэмжээ 14.5 хувь буюу сүүлийн 11 жилийн үнэмлэхүй түвшинд буурна.

Эдийн засгаа дэмжих үүднээс бодлогын хүүгээ бууруулсан 2008, 2015 онд дээрхтэй ижил арга хэмжээ авч байхад ч албаны хүмүүс шууд хөшүүрэг биш хэмээн мэдэгдэж байсан юм. Гэтэл дотоодод хурцдаж буй эдийн засгийн удаашрал болон Цагаан ордны бодлоготой уялдан илүү эрс арга хэмжээ авах нь

чухал болж байна.

БНХАУ-ын төв банкны мөнгөний бодлогын хороо бодлогын хүү болон валютын ханш, төлбөрийн тэнцлээ тэнцвэржүүлэх арга хэмжээгээ зогсоохоо саяхан мэдэгдлээ. Валютын ханшийг тогтворжуулах ХАБ-ны хүчин чармайлт юанийн ханшийн уналтыг торгоож дөнгөхгүй байгаа. Ам.доллартай харьцуулсан юанийн ханш он гарсаар бараг 10 хувиар унасан нь зохицуулах байгууллагын

хяналтаас хэтэрсэн. Гэхдээ 2015, 2016 онд хэрэгжүүлсэн хөрөнгийн урсгалд хяналт тавих арга хэмжээ мөнгөний ханшийг эрс унахаас аварч чадсан. Харин АНУ-ын мөнгөний бодлогыг чангатгасаар байгаа нь Холбооны Нөөцийн Системийн үйл ажиллагаа ам.доллартай харьцуулсан юанийн ханшийг сулруулж, Хятадын валютыг үнээ алдахад хүргэж байна.

Эдийн засгийн өсөлт нь төв банкинд мөнгөний бодлогоо

хэвээр үргэлжлүүлэх нөхцөл бүрдүүлж өгдөг. Ийм нөхцөлд валютын ханшийг тогтворжуулах үүднээс бодлогын хүүг үл ялиг нэмэх боломж ч бий.

Гэтэл өнөөгийн эдийн засгийн өсөлт төв банкны бодлогын хүрээнд тооцоолсноос ч ноцтой удаширч буй бололтой. Статистик илэрч амжаагүй худалдааны дайны сөрөг нөлөө 2019 оны эхнээс ил гарч эхэлнэ. Энэ үеэс орон нутгийн удирдлагын зээлд тавих хяналт, үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хязгаарлалт улам чангарч Хятадын өр зээлд түшиглэсэн өсөлтийн загварыг арагш чангаах юм. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 6.5 хувьд хүргэх Засгийн газрын зорилт нь энэ онд биелэхээр байгаа ч ирэх онд давтагдах магадлал муутай.

Ийм нөхцөлд ялангуяа, АНУ-ын Холбооны Нөөцийн Систем бодлогын хүүгээ 2019 онд өсгөх тохиолдолд бодлогын хүү болон валютын ханшийг жолоодох ХАБ-ны чармайлт үр дүнгээ өгөх боломжгүй болно. БНХАУ-ын төв банк зээл, хадгаламжийн хүүг биш юм аа гэхэд банк хоорондын зах зээлийн хүүг бууруулах гэх мэт аргаар мөнгөний илүү зөөлөн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай тулгарна.

Тус улс нөөцийн хэмжээгээ бууруулахын зэрэгцээ хэрэглээг дэмжихэд чиглэсэн эрс шинэчлэл өрнүүлэх шаардлагатай. Ингэж байж эдийн засаг тэнцвэржиж, зах зээлд итгэх итгэл бэхжин, илүү их хөрөнгө оруулалт татах болно.

FT

► Хоригоос шалтгаалан газрын тосны үнэ өсөж болзошгүй



Дэвид Шеппард

Ираны эрчим хүчний экспортод тавьсан хориг хэрэгжиж эхлэх өдөр ойртож буйгаас үүдэн газрын тос үнэд орсныг дэлхийн нефтийн тэргүүлэх худалдаачид хоёр янзаар таамаглаж байна.

Газрын тосны зах зээлд хомсдол үүсэхгүй хэмээн дэлхийн эрчим хүчний тэргүүлэх бие даасан Vitol компанийн тэргүүн Иэн Тэйлор лхагва гарагт Oil & Money хуралдаан дээр мэдэгдлээ. Хомсдолгүйн зэрэгцээ эрэлт багасах шинж илэрч эхэлсэн учир баррель нь 65 ам.доллар орчимд бууна хэмээн тэрбээр үзсэн юм. Харин Vitol-ын гол өрсөлдөгч Trafigura компанийн тэргүүн Жереми Вейр эсрэг бодолтой байгаагаа Лондонд болсон тус арга хэмжээн дээр илэрхийллээ. Сүүлийн 12 сард Brent тос бараг 50 хувиар үнэд орж баррель нь 85 ам.доллар болсонтой уялдан үнэ цаашдаа "гурван оронтой тоо"-гоор хэмжигдэнэ хэмээн тэрбээр тайлбарлав.

► АНУ-ын бага хөрөнгөтэй компаниудын үнэлгээ уналаа



Николь Баллок

Хөрөнгө оруулагчдын түгшүүр худалдааны дайнаас өрийн хэмжээнд шилжсэнтэй уялдан small cap буюу зах зээлийн үнэлгээ нь 300 саяас хоёр тэрбум ам.долларт эргэлддэг жижиг компаниудын хувьцааны үнэ Уолл-Стрийтэд аварга өрсөлдөгчдийнхөөс нь илт хоцорч эхлэв. АНУ-ын эдийн засаг сайжирсны ачаар Сангийн яамны үнэт цаасны өгөөж сүүлийн долоо жилийн үнэмлэхүй түвшинд өслөө. Үндэстэн дамнасан том компаниудын хэмжүүр болдог S&P 500 индекс сүүлийн долоон хоногт 1.5 хувиар буурсан. Харин жижиг компаниудын хөрөнгө чадлыг илтгэдэг Russel 2000 индексийн уналт үүнээс хоёр дахин их байна.

"Бага хөрөнгөтэй компаниудтай холбоотой гол түгшүүр хөшүүрэг их ашигладаг явдал" хэмээн Bank of America Merrill Lynch-ийн үнэт цаасны стратегич Кэри Холл тайлбарлав.

► АНУ-д хувьцааны үнэ буурсан нь Токиод нөлөөлөв



Элис Вудхаус

Уолл-Стрийтэд хөрөнгийн үнэлгээ сүүлийн найман жилд тохиолдоогүй унасан тул пүрэв гарагт Японы хөрөнгийн зах зээл ч эрс уналттай тулав. Токиод TOPIX индекс 3.4 хувиар суларсан нь гуравдугаар сараас хойш тохиолдоогүй нэг өдрийн үнэмлэхүй уналт болов. Уналт индексийн бүх салбарыг нийтэд нь хамарсан юм. Санхүүгийн сегмент 3.1, технологийн салбарынх 3.2, аж үйлдвэрийнх 3.6 хувиар тус тус буурчээ. Уналт Ази, Номхон далайн бүсийн бусад хэсгийг ч хамарлаа. Сиднейн S&P/ASX 2.3 хувиар суларсан бол Хонконгод Hang Seng индекс 1.4 хувиар буурав. Лхагва гарагт АНУ болон Европт технологийн салбарын үнэлгээ зэрэгцэн унасан нь дээрх бууралтад нөлөөлсөн гэж шинжээчид анхааруулж байна.

MAZDA CX-5

ALBAN ESNY ДИСТРИБЬЮТЕР
БОДИЗ АВТОМОТИВ
THE AUTOMOTIVE EXPERT

SKYACTIV TECHNOLOGY

Нэмэлт хүч
Шатахуун хэмнэлт

88111939, 88021939 | sales@bodizautomotive.mn | www.bodizautomotive.mn | www.facebook.com/bodizautomotive

Бөс даавуу, бэлэн хувцас үйлдвэрлэлээр тэргүүлэх Вьетнамын амбийц

Вьетнамын экспортын ихэнхийг нэмүү өртгийн багагүй татвар шингэсэн импортын бөс даавуугаар хийсэн бүтээгдэхүүн эзэлдэг. АНУ-тай хийдэг худалдааных нь ашиг огцом өсөж буй Вьетнам орон Вашингтоны эгдүүг хүргэхгүй гэвэл дотооддоо бөс даавуу үйлдвэрлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ бусад зах зээлд борлуулах шаардлагатай.

Бөс даавуу, бэлэн хувцас нь Вьетнам 1990-ээд оны эхээр эдийн засгаа нээлттэй болгосон үеэс тус улсын үйлдвэрлэлийн нэг суурь болсон юм. Фермээ орхин үйлдвэрүүдэд шилжиж ажилласан хөдөөгийн бага цалинтай ажилчдын ачаар уг салбар валютын найдвартай эх булаг болж хувирчээ.

Вьетнам нь 2017 онд бөс даавуу, бэлэн хувцасны экспортоор Бангладеш, ХБНГУ, Италийг гүйцэж түрүүлэн дэлхийд гуравдугаар байр эзэлдэг болсон. Эдүгээ тус улсын өмнө ердөө БНХАУ, Энэтхэг орж байна.

“Вьетнамд үйлдвэрлэв” шошготой бөс даавуу, бэлэн хувцасны экспорт 2007-2017 онд бараг тав дахин ихэссэн. Экспорт сүүлийн таван жилийн турш жилд дунджаар 15 хувиар өсөж ирснийг НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Конференц (ЮНКТАД) тооцоолжээ.

Вьетнам нь он гарахаас өмнө бөс даавуу, бэлэн хувцасны экспортоор Энэтхэгийг гүйцэж түрүүлнэ. Албан ёсны статистикаас үзвэл 1-8 дугаар сард экспорт 16.9 хувь өссөн нь жилийн өмнөх үеэс хоёр дахин өндөр үзүүлэлт.

Бөс даавуу, бэлэн хувцасны экспорт нь Вьетнамын хоёр дахь чухал таваар. Ажиллах хүчний тоогоор ч улсдаа толгой цохьдог. Ажиллах хүчний зардал нь өссөөр байгаа уг салбарт нийт 2.7 сая хүн ажиллаж байгааг Вьетнамын бөс



Вьетнам улс ирэх жилээс өмнө бэлэн хувцас, бөс даавууны экспортоор дэлхийд хоёрдугаар байр эзлэхээр бэлтгэж байгаа ч баяр тэмдэглэхэд эрт хэвээр.


даавуу, бэлэн хувцасны холбооны (VITA) статистикаас үзэж болно. Энэ нь тус улсын нийт ажиллах хүчний таван хувь, аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын 20 хувь болж байна.

Бусад улстай харьцуулахад Вьетнамын экспорт бахдам өссөн нь хүн ам, газар зүйн таатай нөхцөл, нээлттэй худалдааны бодлогын ач юм. Тус улс Европын Холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар бэлтгэж буй. Мөн анхны Транс-Номхон Далайн Түншлэл (TPP) ч тус улсад цутгах гаднын хөрөнгө оруулалтыг аварга өсгөж өгсөн юм. Вьетнамын бэлэн хувцас, бөс

даавууны үйлдвэрлэлийн салбарт 1998 оноос хойш оруулсан 15.7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын хагас нь ердөө сүүлийн таван жилд оржээ.

Өргөжин тэлсээр байгаа ч Вьетнамын бөс даавуу үйлдвэрлэлийн хүчин чадал сул хэвээр. Вьетнамд үйлдвэрлэдэг бэлэн хувцаст ашиглаж буй бөс даавууны 70-80 хувь нь БНХАУ-д үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн.

Вьетнамын Засгийн газрын статистикийн хорооны тооцоогоор тус улсын бөс даавуу, бэлэн хувцасны нийт өртгийн ердөө гуравны нэг нь цэвэр дотоодын үйлдвэрлэл бол, үлдсэн бусад



нь импортын түүхий эдийнх. Гэхдээ ухаалаг утас, цахим бүтээгдэхүүний өртгийн 20 хүрэхгүй хувь нь дотоодынх болдогтой харьцуулахад энэ нь бас ч сайн үзүүлэлт.

Тус улс гадаад зах зээлээ улам төрөлжүүлэх шаардлагатай нь бас нэг анхаарах зүйл. Одоогоор Вьетнамын бөс даавуу, бэлэн хувцасны экспортын бараг тал хувь нь АНУ-д ноогддог. Бөс даавуу, бэлэн хувцасны үйлдвэрлэлийн жинхэнэ чухал зангилаа болохын тулд тус улс үнэ цэнийн гинжин хэлхээ (value chain) үүсгэх шаардлагатай байгаа юм.

Ирээдүйн төлөөх Toyota, SoftBank-ийн түншлэл



Кана Инагаки

Toyota компани автомат жолоодлогот автомашины төрөл бүрийн үйлчилгээнд Softbank-тай хамтран ажиллахаар боллоо. Хүнс, бараа хүргэлтээс эмнэлгийн хяналт хүртэлх янз бүрийн үйлчилгээг хамарч буй уг хамтын ажиллагаа нь авто үйлдвэрлэгч автомат жолоодлогын эринд технологийн групптэй тогтоосон харилцаагаа гүнзгийрүүлэхийг хичээж буйн илрэл юм.

Авто үйлдвэрлэгч сүүлийн жилүүдэд бизнесийн уламжлалт групп, холбоодын оронд Uber, Amazon зэрэг технологийн компани-тай хамтрах замаар автомашин үйлдвэрлэх, нийлүүлэхээс өөр аргаар мөнгө олоход анхаарч ирлээ.

Уг түншлэлээр Toyota-гийн автомат жолоодлогын технологийг SoftBank-ийн зүйлсийн интернэтийн платформтой хослуулна. Monet Technologies нэрийн дор 17 сая ам.доллараар хамтран байгуулж буй шинэ компани нь Toyota хөгжүүлдэг автомат жолоодлогот автомашиныг ашиглан хөдөлгөөнт үйлчилгээ нэвтрүүлэх аж.

Энэ удаагийн түншлэлээс өмнө Японы хоёр компани хамтран ажиллаж байгаагүй.

“Toyota ердөө л автомашин үйлдвэрлэдэг байсан тэртээх үед SoftBank шиг компани-тай хамтрах арга байгаагүй. Харин бид хөдөлгөөнт компани болох зорилт тавиад байгаа 20 жилийн дараа ийм түншлэл амин чухал” хэмээн Toyota-гийн гүйцэтгэх захирал Акио Тойода Токиод болсон хэвлэлийн хамтарсан хурал дээр мэдэгдэв. Ирээдүйд чиглэсэн спот технологи хөгжүүлэх Softbank-ийн чадвар тус компанийн сонирхлыг татаж байгааг гүйцэтгэх захирал нэмж дурдлаа.

SoftBank оны эхээр АНУ-ын GM компанийн автомат жолоодлогот машин хөгжүүлэх Cruise салбарт 2.25 тэрбум ам.долларын хөрөнгө оруулсан. Хөрөнгө оруулалтыг Саудын Арабын дэмжлэгтэй 100 тэрбум ам.долларын Vision сангаар дамжуулан олгожээ. Cruise нь Японы Honda компаниас мөн 2.75 тэрбум ам.долларын санхүүжилт татаж чад-санаа лхагва гарагт мэдэгдсэн юм.

АМЕРИКИЙГ БҮТЭЭСЭН
АВТОМАШИНУУД

Bloomberg TV Mongolia

Мягмар гараг /2018.10.16/

20:30

14:00 Лхагва гараг

15:30 Бямба гараг

19:00 Ням гараг

Эдийн засаг

Өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд хуримтлал хэрэгтэй

Анх удаа 553 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд хадгална

Ч.Баатар
ЗГМ

Төсвийн тодотголын хэлэлцүүлэг өрнөж буй энэ үед төсвийн хөрөнгө оруулалтыг яаж ашигтай зарцуулах, төсвийн алдаглыг хэрхэн бууруулах болон зээлийн хүүгийн асуудал халуун сэдэв болоод байна. Энэ талаар УИХ-ын гишүүн, эдийн засгийн шинжлэх ухааны доктор Б.Баттөмөртэй ярилцлаа.

-Засгийн газар төсвийн орлогыг 11.6 их наяд төгрөг буюу батлагдсан түвшнээс 2.4 их наядаар нэмсэн. Ийм боломж бий юу?

-Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв санг хасаад төсвийн орлого 9.6 их наяд төгрөг, зарлага нь 11.5 их наяд төгрөг гэж төлөвлөж байгаа. Бид төсвийн орлогыг өөдрөгөөр харах хэрэгтэй. Манайх шиг баялагтай, уудам газар нутагтай улсын хувьд төсвийн орлогын ирээдүй өдрөг. Энэ удаад 2010 оноос хойших бүхий л бодит боломжийг дайчилсан төсөв болж байна. Гэхдээ үүнээс ч сайн төсөв гарах боломжтой.

-Төсвийн алдагдал хоёр их наяд орчим төгрөг болох нь. Үүнийг цаашид бууруулах боломж бий юу?

-Ирээдүйн өв санд 1.1 их наяд төгрөг, өрөө төлсний дараах 553 тэрбум төгрөгийг Монгол Улс анх удаа ирээдүйдээ зориулан хадгална. Харин төсвийн алдагдлын 1.9 их наяд төгрөгийг ДНБ-тэй харьцуулахад 5.4 хувь байгаа юм. Өнгөрсөн хавар төсвийн хүрээний мэдэгдлийг баталсан. Үүнд төсвийн алдагдлыг 6.1 хувиас хэтрүүлэхгүй гэж хязгаар тавьсан. Төсвийн орлогыг 780 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн учраас зарлага нь 600 орчим тэрбум төгрөгөөр мөн ахисан. Иймд мөн л төсвийн хүрээний мэдэгдлээ хангасан сайн төсөв болж байна.

-Хөрөнгө оруулалтын зардлын хэмжээг мөн хоёр дахин нэмлээ. Яавал хөрөнгө



Цаашид төсвийн хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлогод чиглүүлэх шаардлага бий.

Б.Хасуй / ЗГМӨ

оруулалтыг үр ашигтай байлгах вэ?

-Хөрөнгө оруулалтад 700 гаруй тэрбум төгрөг төсөвлөсөн ч үүнийг хоёр дахин нэмж, 1.4 их наяд төгрөг болгосон. Мэдээж Монгол Улсад хийх зүйлс маш их бий. Гэхдээ эдийн засгаа “хөгжлийн” эдийн засаг болгох хэрэгтэй. Үүний тулд төсөв ч мөн хөгжилд чиглэх ёстой. Тиймээс эдийн засгийн өсөлт хамгийн их бий болдог салбартаа хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Одоогоор гурван ээлжээр хичээллэдэг сургууль, цэцэрлэгт орж чадаагүй хүүхдүүд олон байгаа болохоор 40 сургууль, 60 цэцэрлэг, 32 эмнэлэг, 27 спорт заал барих ажил зайлшгүй болоод байна. Мөн дуусгаж чадаагүй ажлуудад хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа. Цаашид илүү хөгжиж, нэмүү өртөг бүтээж, өрсөлдөх

чадвараа сайжруулахын тулд илүү их хуримтлалтай болох ёстой. Мөн энэ жилийн хувьд хөгжлийн чиглэлд хийж байгаа хөрөнгө оруулалт харьцангуй бага байна. Цаашид төсвийн хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлогод чиглүүлэх шаардлага бий.

2021-2023 онд инфляцыг зургаан хувьд барих төлөв гарсан

-Төв банкны үйл ажиллагааг үлс төрөөс хараат бус, бие даасан байхаар хуульч өөрчлөлт орсон. Энэ нь эдийн засагт хэр бодит

нөлөө үзүүлэх бол?

-Банкны системийн эрхзүйн шинэчлэл дуусаж байна. Гэхдээ банкны салбарын энэхүү эрхзүйн шинэчлэл нь Актив удирдлагын тухай, Валютын зохицуулалтын тухай болон Санхүүгийн хэрэг-лэгчийг хамгаалах тухай хуулийн томъёололд суурилж буй. Мөнгөний бодлогын хувьд макро эдийн засгийн зохистой бодлогыг мөнгөний бодлоготой уялдуулах замаар инфляцыг 2019, 2020 онд найман хувьд барина. Дунд хугацаанд буюу 2021-2023 онд инфляцыг зургаан хувьд барих төсөөллийг оруулж ирээд байгаа.

-Сүүлийн нэг сарын хугацаанд ам.долларын ханш төгрөгийн эсрэг зургаан хувиар өслөө. Энэ нь Монгол Улсын макро эдийн засагт яаж нөлөөлөх вэ?

-Эдийн засаг тэлснээр импорт

нэмэгдсэн нь ам.долларын ханш өсөхөд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Мөн энэ оны эхний хагас жилийн байдлаар 4.7 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүнийг манай улс гадаад руу гаргасан байна. Гэсэн хэдий ч эргээд Монголын эдийн засагт орж ирсэн ашгийг харуулах тоо алга. Иймээс л Валютын зохицуулалтын тухай хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлага гарсан.

-Эдийн засгийн загварыг өөрчлөх талаар та ямар байр суурьтай байна вэ?

-Энэ бол тийм ч шинэ сэдэв биш. Монголын эдийн засагт 2000 оноос хойш ажиглагдаж байгаа үзэгдэл. Хамгийн харамсалтай нь, энэ сэдвийг маш цөөхөн хүн ярьдаг. Нэгдүгээрт, төрийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай. УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцангаар ахлуулсан Үндсэн хуульд өөрчлөлт оруулах Ажлын хэсэг байгуулагдсан. Гэхдээ энэ ажлын хүрээнд төрийн тогтолцоонд томоохон өөрчлөлт хараахан гарахгүй ч Үндсэн хуульд өөрчлөлт оруулах цаг болсон. Төрийн тогтолцоонд өөрчлөлт хийвэл эдийн засгийн загвар ч мөн өөрчлөгдөнө. Манай улсад төрийн болон хувийн өмчийн харилцаанд маш олон өөрчлөлт, зохицуулалт л хэрэгтэй.

-Монголбанк зээлийн хүү бууруулах стратеги боловсруулж байгаа. Өнөөдрийн байдлаар зээлийн хүүг бууруулах шаардлага бий юу?

-2018-2023 онд хооронд зээлийн хүүг бууруулах чиглэлд идэвхтэй ажиллаж, хөтөлбөр боловсруулахыг УИХ-аас Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Сангийн яаманд үүрэгдсэн. Энэ хүрээнд тус гурван байгууллага хадгаламжийн даатгалыг оруулан зээлийн хүүг бууруулах стратеги боловсруулсан. Харин одоо үүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж байгаа. Зээлийн хүүг бууруулахын тулд анхаарч ажиллах үндсэн гурван асуудал бий. Нэгдүгээрт, захиргааны аргаар зээлийн дээд хүүг шууд тогтоох нь тийм ч оновчтой биш. Хоёрдугаарт, макро эдийн засгийн орчныг тогтвортой болгох шаардлагатай. Гуравдугаарт, банкуудын эрсдэл даах чадавхыг дээшлүүлж, засаглалыг дэмжих юм. Эдгээр ажлыг хийснээр зээлийн хүү буурна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ТЕХНОЛОГИ

917

Ам.доллар. Mercedes-Benz компани устөрөгчийн түлшээр ажилладаг цахилгаан автомашинаа Герман улсын зах зээлд нийлүүлэхээр боллоо. Тус компани цахилгаан автомашинаа хэрэглэгчдэд сарын 917 ам.доллараар түрээслэх аж. Мөн Daimler, Linde компаниуд хамтран ирэх онд устөрөгчийн шатахуун түгээх 100 станц байгуулахаар төлөвлөжээ.

» АШИГТ МАЛТМАЛ

3.3

Их наяд төгрөг. Умард Солонгосын ашигт малтмалын нөөц 3.3 их наяд ам.доллараар үнэлэгдэж буй нь Өмнөд Солонгостой харьцуулахад 15 дахин их үзүүлэлт юм. Умард Солонгост зургаан тэрбум тонн магнезит, хоёр сая тонн бал чулуу, 250 мянган тонн вольфрам буюу гянтболд байдаг аж. Тэдгээрийг олборлоход гаднын компаниудтай хөрөнгө оруулалт хийх тухай 40 гэрээ хэлэлцээрт Умард Солонгосын эрх баригчид гарын үсэг зуржээ.

» АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

301

Ам.доллар. Дубай хот жуулчдын хамгийн үнэтэй хотуудын жагсаалтыг тэргүүлжээ. Аялагчид тус хотод дунджаар 537 ам.доллар зарцуулдаг байна. Харин Парис хот 301 ам.доллараар жагсаалтын хоёрдугаарт орсон бол Сингапур 286 ам.доллараар гуравдугаар байранд жагсжээ. Түүнчлэн эхний тавд Сөүл 181 ам.доллараар, Бангкок хот 173 ам.доллараар тус тус бичигдсэн байна.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

3

Тэрбум ам.доллар. БНХАУ тав, арав, гучин жилийн хугацаатай гурван тэрбум ам.доллар бүхий үнэт цаас гаргахаар төлөвлөөд буй. Харин энэ оны байдлаар 125 тэрбум ам.долларын бонд гаргаад байна.

» ТӨСӨЛ

45

Сая ам.доллар. АНУ-ын Батлан хамгаалах яам сансрын пуужин бүтээхэд нэг тэрбум ам.доллар зарцуулахаар болжээ. Зөвхөн нэг удаа ашиглах зориулалттай 967 сая ам.долларын зөөгч пуужин бүтээх сонгон шалгаруулалтад United Launch Services консорциум ялжээ. Түүнчлэн ATK Launch Systems компани зөөгч пуужин бүтээх төсөлд 45 сая ам.доллар гаргажээ. Мөн Америкийн SpaceX компани Raptor пуужингийн хөдөлгүүр бүтээх төсөлд 33.6 сая ам.долларын санхүүжилт авсан байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,563.77
Евро	2,958.85
Японы иен	22.84
ОХУ-ын рубль	38.39
БНХАУ-ын юань	370.06
БНСУ-ын вон	2.24

ОЛБОРЛОЛТ

2027 онд цайрын олборлолт 16.8 сая тонн хүрэх төлөвтэй байна



Дэлхийн зах зээлд цайрын үнэ нэмэгдсэнээр ирэх жилүүдэд олборлолт өсөх төлөвтэй байгааг Fitch Solutions болон Macro Research судалгааны байгууллагууд цайрын олборлолтын нэгдсэн судалгаандаа онцоллоо.

Fitch-ийн судалгаагаар 2018 онд цайрын олборлолт дэлхийн хэмжээнд 2.3 хувиар өсөж, 13.7 сая тонн хүрэх бол 2027 онд 16.8 сая тонн болтлоо өсөх хандлагатай байна. Уг судалгаагаар дэлхийн

цайр олборлогч 10 том компанийн жагсаалтыг Энэтхэгийн Ram-pura Agucha компани тэргүүлж, АНУ-ын Red Dog, Перугийн Antamina компаниуд удаалсан байна. Харин БНХАУ-ын байгаль орчны зохицуулалт нь цайрын олборлолт зогсонги байдалд ороход нөлөөлж болзошгүй байгаа аж. Хэдий тийм ч БНХАУ цайрын зах зээлд гол тоглогч хэвээр байна гэдгийг шинжээчид хэлж буй юм.

ТҮҮХИЙ ЭД

Нүүрсний экспорт 27 сая тоннд хүрлээ

Т.Элиса
Шинжээч

Энэ оны эхний есөн сард Монгол Улс 27 сая тонн нүүрс экспортолжээ. Энэ нь жилийн өмнөхөөс зургаан хувиар өссөн үзүүлэлт болж байна. Харин нэг тонн нүүрсний дундаж ханш 16 хувиар өсөж, 78.5 ам.доллар болжээ. Ирэх онд 42 сая тонн нүүрс экспортолно хэмээн Сангийн яам 2019 оны төсөвт тусгаад буй. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар гаалийн хяналтын шинэчлэл хийснээр экспортоо нэмэх боломжтой гэж үзэж буй аж. Одоогоор зургаан боомтын нэвтрэх чадвар, хяналтыг сайжруулахаар ажиллаж байна. Гашуунсухайт боомтын нэвтрэх хүчин чадал есдүгээр сараас хойш эрс сайжирч, өдөрт



С.Батсайхан / ЗГМӨ

1250-1350 машин нүүрс ачин гарч байгааг “Гашуунсухайт авто зам” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Болд мэдэгдлээ. Он гарснаас хойш Гашуунсухайт боомтоор нийт 14 сая тонн

нүүрс экспортолжээ. БНХАУ-ын талтай ямар зөвшилцөлд хүрээс Монголын нүүрсний экспорт хамаарна гэж Дэлхийн банкны аллах эдийн засагч Жон-Паскаль онцолсон юм.

Эдийн засаг

1072 хувьцаатай иргэдийн 72 хувь нь үнэт цаасны дансгүй

Иргэдийн мэдлэгийг сайжруулахгүйгээр хөрөнгийн зах зээл хөгжихгүй

Б.Баярмаа
@bayarmaaZGM

“1072 хувьцааг худалдаж авч байгаа нь үнэн үү?” гэсэн асуулт “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дэргэдэх “1072 хувьцаа мэдээллийн төв”-ийн утсанд зогсоо зайгүй ирж байна. Тус төвөөр өдөрт 70 гаруй иргэн үйлчлүүлж, мэдээлэл авдаг. Харин “Эрдэнэс Тавантолгой”-н нэгж хувьцааг 5000-8000 төгрөгөөр худалдаж авна гэсэн хуурамч мэдээлэл тарсны дараа төвийн ачаалал эрс нэмэгджээ. Ойрын өдрүүдэд үйлчлүүлэгчдийн тоо 100 давсан байна. Мөн утасны дуудлага ч огцом өссөн аж.

Өчигдөр “Эрдэнэс Тавантолгой” компаниас иргэдэд дээрх мэдээлэлд хууртахгүй байхыг сэрэмжлүүлж, мэдэгдэл гаргасан. Тус компанийн хувьцааг хөрөнгийн зах зээл дээр албан ёсоор гаргаагүй учраас хувьцааг нь арилжих эрх нээгдээгүй байгаа юм. Харин 1072 хувьцааг худалдаж авна гэсэн зар сошиал орчинд олон нийтээс хандалт авах гэсэн зорилготой, зохион байгуулалттай үйлдэл гэдгийг мэргэжилтнүүд тайлбарлалаа.

УИХ болон Засгийн газар шийдвэр гаргаж “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны 10 хувийг аж ахуйн нэгжид, мөн ийм хэмжээтэйг 2014 оны дөрөвдүгээр сарын 11-нээс өмнө төрсөн Монгол Улсын иргэн бүрт олгосон. 1072 хувьцаа нь нэг сая төгрөгтэй дүйцэх бөгөөд нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоосон. Засгийн газрын шийдвэрт мөн тус компанийн хувьцааг хөрөнгийн зах зээл дээр гаргах хүртэл иргэдийн эзэмшиж буй хувьцаа нь саналын эрхгүй, аливаа хэлбэрээр захиран зарцуулах боломжгүй байхаар заасан юм. Харин тус компанийн төрийн мэдэл дэх 30 хувийг Хонконгийн хөрөнгийн бирж дээр гаргах эрхийг УИХ-аас Засгийн газарт олгоод буй. Энэ дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон бусад холбогдох байгууллагууд энэ онд багтаан шаардлагатай бэлтгэлийг хангахаар ажиллаж байна. Өөрөөр хэлбэл “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааны 30 хувийг хөрөнгийн бирж дээр гаргасан өдрөөс иргэд 1072 ширхэг хувьцаагаа арилжих эрхтэй болно гэсэн үг.



С.Батсайхан / ЗГМ©



1072 хувьцааг худалдаж авна гэсэн хуурамч мэдээлэл тарснаар “1072 хувьцаа мэдээллийн төв”-ийн ачаалал эрс нэмэгджээ.

Өнөөдрийн байдлаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТХТ)-д сая гаруй иргэн, аж ахуй нэгж үнэт цаасны данс нээлгээд байна. Эдгээрийн 700 гаруй мянга нь Монгол Улсын иргэдийнх бол үлдсэн 500 гаруй мянга нь компаниуд болон гаднын иргэдийнх. Тодруулбал, “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 хувьцааг эзэмшдэг 2.5 сая иргэний дөрөвний нэг нь буюу 28 хувь нь л үнэт цаасны данстай.

● **1072 хувьцааг худалдаж авна гэсэн зар сошиал орчинд олон нийтээс хандалт авах гэсэн зорилготой, зохион байгуулалттай үйлдэл гэдгийг мэргэжилтнүүд тайлбарлалаа.**

● **Төр иргэддээ хувьцаа олгож, хөрөнгийн зах зээлийн нэг оролцогч болгосон юм бол энэ зах зээлийн талаарх мэдлэгийг нь дээшлүүлэхийг бодлогын хэмжээнд авч үзэх ёстой.**

● **“Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг эзэмшдэг 2.5 сая иргэний бараг дөрөвний нэг нь буюу 28 хувь нь л үнэт цаасны данстай.**



“Эрдэнэс тавантолгой” ХК, УУХУЯ©

Харин 1072 хувьцаатай иргэдийн үлдсэн 72 хувь нь дансаа нээлгээгүй байна. Гэхдээ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд гаргах шийдвэр гарснаас хойш үнэт цаасны данс нээлгэх иргэдийн тоо харьцангуй өссөн байна. Өнөөдрийн байдлаар гэхэд шинээр данс нээлгэх гэсэн 10 мянган иргэний хүсэлт ирсэн, хүлээгдэж байгаа аж.

Гэхдээ зарим иргэд үнэт цаасны нэгээс олон данс бүртгүүлсэн байдаг. Тухайлбал, 1990 онд өмч хувьчлах үеэр 500 гаруй мянган иргэн үнэт цаасны данс нээлгэсэн ч ихэнх нь хаалгүй мартсан байдаг аж. Зарим нь үүнийгээ шалгалгүйгээр дахин данс нээх тохиолдол цөөнгүй гардаг юм байна. Гэтэл зарим брокерийн пүүс данс нээх хураамж авахын тулд өмнө нь данс нээсэн эсэхийг нь шалгаж өгдөггүй,

иргэд ч шалгуулах ёстойгоо мэддэггүй аж. Хэрэв 1990-ээд онд данс нээсэн бол түүнийг өнөөдөр ч ашиглах боломжтой байдаг. Түүнчлэн, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа амь орно, ногдол ашиг тараана гэсэн мэдээллийг ашиглан орон нутгийн иргэдийг хуурах тохиолдол цөөнгүй гарч байгаа аж. Орон нутагт брокерийн компанийн нэр ашиглаж, үнэт цаасны данс нээх нэрээр иргэдээс мөнгө авах тохиолдол мэр сэр гарч байгаа аж. Тиймээс орон нутгийн иргэдийг данс нээлгэх гэж буй бол ажилтных нь бичиг баримт, компанийнх нь зөвшөөрлийг шалгаж байхыг мэргэжилтэн анхааруулсан юм.

1072 хувьцааны сошиал сүлжээнээс эхтэй дуулиан нэг талаас иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг тааруу байгааг харууллаа. Хэдийгээр Монголын хөрөнгийн бирж,

“1072 хувьцаа мэдээллийн төв” тогтмол хугацаанд хөрөнгийн зах зээлийн талаарх анхан шатны сургалт явуулж буй ч иргэдийн идэвх сул байдаг аж.









Давхардсан тоогоор 700 мянга гаруй иргэн үнэт цаасны данс нээсэн

ҮЦТХТ-ийн захирал Ш.Лхагва “Иргэдийн санхүүгийн, тэр дундаа хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг тун тааруу байна. Төр иргэддээ хувьцаа олгож, хөрөнгийн зах зээлийн нэг оролцогч болгосон юм бол энэ зах зээлийн талаарх мэдлэгийг

нь дээшлүүлэхийг бодлогын хэмжээнд авч үзэх ёстой. Ялангуяа, Монголбанкнаас олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдийн ойлголт, мэдлэгийг сайжруулах шаардлагатай байна” гэв.

“Эрдэнэс Тавантолгой” компани өнгөрсөн онд 8.5 сая тонн нүүрс экспортолж, Монголын нүүрсний нийт экспортын 25 хувийг дангаараа бүрдүүлсэн. Энэ оны эхний хагас жилд 953 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан тус компани энэ онд улсын төсөвт 285 тэрбум төгрөг төвлөрүүлэх ёстойгоос 216.5 тэрбум төгрөгийг нь шилжүүлээд буй. Үүнд энэ онд Зүүн Цанхийн уурхайн нэг тонн нүүрсний үнэ 59.33 ам.доллараас 61 ам.доллар болж нэмэгдсэн, Баруун Цанхийн нүүрсний үнэ 69-70 ам.доллараас дээш тогтоосон нь нөлөөлсөн юм. (ЗГМ)

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:



DOW JONES	S&P 500	FTSE 100	NIKKEI 225	TOPIX	SHANGHAI COMPOSITE	HANG SENG	KOSPI
3.15%	3.29%	1.80%	3.89%	3.45%	5.22%	3.54%	4.44%